

## Алсын хараа - 2050

### Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2024 он

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>Хоёр. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>							
1	2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.	2.1.43. Нээлттэй боловсролын тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээнэ.	2020 - 2050	-	-	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/473, А/221 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Улаанбаатар хот болон орон нутаг дахь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэн, хүлээлгэн өгсөн болно.</p> <p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн богино хугацааны мэргэшүүлэх сургалтын бодлого хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Мэргэжлийн сургалтын бодлогын шинэчлэл, цаашдын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн сургалтын байгууллагын удирдлага мэдээллийн нэгдсэн систем <a href="http://www.mergejil.mn">www.mergejil.mn</a>-ийг дараах модулийн хүрээнд хөгжүүлэлт хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Олон нийтийн портал удирдлага</li> <li>➢ Сургалтын хөтөлбөрийн удирдлага</li> <li>➢ Суралцагчийн модуль</li> <li>➢ Чадамжийн гэрчилгээний нэгдсэн сан+RPL</li> <li>➢ Сургалтын байгууллагын бүртгэл, бүртгэлийн гэрчилгээний удирдлага</li> <li>➢ Цахим төлбөрийн хэрэгслүүдийг нэвтрүүлэлт, төлбөрийн хяналтын модуль</li> <li>➢ Багш, хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн модуль</li> <li>➢ Мэргэжлийн зөвлөлийн бүртгэл, мэдээллийн модуль</li> </ul> <p>Одоогоор тус системд сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр 1057 сургалтын байгууллагын анхан шатны бүртгэл бүрэн хийгдсэн бөгөөд, 9729 суралцагчдад тус системээр дамжуулан Чадамжийн гэрчилгээ олгосон байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганаар 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдон тоонд өөрчлөлт ороогүй болно.</p> <p>Цаашид дээрх шинээр батлагдсан хуулийн дагаж гарах журмуудын хүрээнд систем хөгжүүлэлт өөрчлөлтийг хийхээр инженерчлэлийн судалгаа хийгдэж байна.</p>	70

2	2.3. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.	2.3.1. Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.	2020 - 2050	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар дунд хугацааны хөгжлийн 7 зорилтот хөтөлбөртэй байхаар хуульчилсан. Дээрх хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийг ЭЗХ-ийн сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар баталж, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсгийн ахлагчаар С.Зулпхар, нарийн бичгийн даргаар А.Хишигбаяр нар ажиллаж байна. НХЗХ-т “Зорилго 1. Хүн амын тогтвортой өсөлт, зохистой бүтцийг бүрдүүлнэ” гэсэн хүрээнд “Зорилт 4.4. Дотоод шилжих хөдөлгөөний зохицуулалтыг сайжруулж, хүн амын байршлын зохимжтой бүтцийг хадгална” гэсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр шилжин суурьшигчдын бүртгэлд хамрагдалтыг сайжруулж, нийгмийн суурь үйлчилгээнд бүрэн хамруулах, орон нутагт шилжин суурьшигчдын бизнес, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, орон сууцны хөнгөлөлт, буцалтгүй тусламж, урамшууллыг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагааг тусгаад байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газар Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шатлгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Хуулийн шинэчлэлээр хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжсэнээр нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын тодорхой хэсгийг 2029 оноос хууль ёсны өв залгамжлагчид өвлүүлэх, тэтгэвэр авагч нас барсан бол Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэр бүлээ бүртгүүлсэн, 20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр, эсхүл нөхрийн тэтгэврийн хэмжээг нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн 20 хувиар 2024 оноос нэмэгдүүлэхээр эрх зүйн орчин бүрдээд байна.</p> <p>Манай улсын хувьд Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд жирэмсэн болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхчүүдэд сар бүр тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхийг Эхийн алдар одонгоор урамшуулж жил бүр тэтгэмж олгох зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэн нь амьжиргааны түвшин харгалздаггүй, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлого юм. Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийн хүрээнд нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан хэрэгжиж байгаа эх, хүүхдэд чиглэсэн дээрх тэтгэмжийг нэгтгэн Хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг шагнаж, урамшуулах тухай хуулийн төслийг шинээр боловсруулж байна. Энэ хүрээнд одоогийн хууль тогтоомжийн хүрээнд үзүүлж байгаа тэтгэмжийг хүн амын өсөлтийг дэмжих бодлоготой уялдуулах, хүүхдийн тоотой уялдуулан олон хүүхэдтэй залуу гэр бүлийг дэмжих, татварын хөнгөлөлт үзүүлэх, орон сууцтай болоход төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан.</p>	90
---	---	--	-------------	---	----

3		<p>2.3.2. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана.</p>	2020 - 2050	83.0	-	<p>-Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийг Улсын Их хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ сурталчлах ажлыг 2024 оны 3 дугаар сараас эхлүүлж, 5 дугаар сарын 20-ныг хүртэл зохион байгуулагдаж, 6300 гаруй төрийн албан хаагч, эцэг эхийн төлөөлөл 240 гаруй хүнд хууль танилцуулж, холбогдох дүрэм, журам, стандартад тусгах санал авч ажилласан.</p> <p>-2024 оны хагас жилийн байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 37 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүчирхийлэлд өртсөн талаар дуудлага мэдээлэл ирүүлж, холбогдох журмын дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Түр хамгаалах байр нэг цэгийн үйлчилгээний төвөөр 12 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлж, аюулгүй байдлыг хангасан.</p> <p>-Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд 91 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>-2024 оны эхний хагас жилийн байдлаар эрсдэлийн программд бүртгэлтэй 21783 хүүхэд байгаагаас 2024 онд шинээр 1113 хүүхдийг эрсдэлийн программд бүртгэн, хүүхэд түүний гэр бүлд Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын дагуу шаардлагатай үйлчилгээг үзүүлэн эрсдэлийг бууруулсан.</p> <p>Түүнчлэн 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 147 хараа хяналтгүй хүүхдийг илрүүлж, эрсдэлийн программд бүртгэж, аюулгүй байдлыг ханган, шаардлагатай хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.</p>	70
4		<p>2.3.3. Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан,</p>	2020 - 2050		<p>Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар дунд хугацааны хөгжлийн 7 зорилтот хөтөлбөртэй байхаар хуульчилсан. Дээрх хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийг ЭЗХ-ийн сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар баталж, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр /НХЗХ/ боловсруулах дэд ажлын хэсгийн ахлагчаар С.Зулпхар, нарийн бичгийн даргаар А.Хишигбаяр нар ажиллаж байна. НХЗХ-т “Зорилго 1. Хүн амын тогтвортой өсөлт, зохистой бүтцийг бүрдүүлнэ” гэсэн хүрээнд “Зорилт 4.4. Дотоод шилжих хөдөлгөөний зохицуулалтыг сайжруулж, хүн амын байршлын зохимжтой бүтцийг хадгална” гэсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр шилжин суурьшигчдын бүртгэлд хамрагдалтыг сайжруулж, нийгмийн суурь үйлчилгээнд бүрэн хамруулах, орон нутагт шилжин суурьшигчдын бизнес, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, орон сууцны хөнгөлөлт, буцалтгүй тусламж, урамшууллыг нэмэгдүүлэх зэрэг үйл</p>	70

		хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.			ажиллагааг тусгаад байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар Монгол Улс урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй байхаар заасан. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан. Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхүйц байхаар тодорхойлж хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байхаар хуульчилсан. Дээрх хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах ажлын дэд хэсгүүдийг ЭЗХ-ийн сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар баталж, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсгийн ахлагчаар С.Зулпхар, нарийн бичгийн даргаар А.Хишигбаяр нар ажиллаж байна. НХЗХ-ийг төслийг СЯ, ХХААХҮЯ, БХБЯ, ЭМЯ, ХЗДХЯ-ны төлөөлөл болон ГБХНХЯ-ны хүн ам, гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийн газрын удирдлага, албан хаагчдад танилцуулж, санал авах ажлыг зохион байгууллаа. Мөн ЭЗХЯ-наас 2 удаа зохион байгуулсан Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх семинарт тус хөтөлбөрийг боловсруулах ажлын багийн бүрэлдэхүүн оролцлоо. Семинарын үеэр хөтөлбөрийн төслийг бусад хөтөлбөртэй уялдуулах, давхардал, хийдэгдлийг арилгах, хариуцах салбар байгууллага, хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг тодорхойлох чиглэлээр бусад хөтөлбөрийн ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа. Хөтөлбөрийн төслийг 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 7 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж, буцаагдсан. Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсгээс 2023 онд хөтөлбөрийн төслийг олон улсын байгууллагын болон төрийн бус байгууллагын төлөөлөлд танилцуулж санал авах ажлыг зохион байгуулж, оролцогчдын саналыг ЭЗХЯ-д хүргүүлсэн.	
			1,3 тэрбум	Хүүхэд харах үйлчилгээний журам, стандартыг шинэчлэн батлуулж, хүүхэд хүлээж авах бэлтгэлийг хангасан байна.	Улсын хэмжээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар хүүхэд харах үйлчилгээний 115 төвд 326 хүүхэд харагч ажиллаж 1528 хүүхэд хамрагдсанаас 184 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Сар бүр 15 аймаг, 6 дүүргээс Хүүхэд харах үйлчилгээний журмын дагуу мэдээллийн санг бүрдүүлж, сар бүр мэдээллийг шинэчлэн санхүүжилтийг олгож байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1,3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Үйлчилгээнд зорилтод бүлгийн, алслагдсан бүс нутгийн, хилийн заставын нийт 102 төвийн, нийт 411 хүүхдийг хамруулсан. ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 ны 04 сарын О/108 тоот тушаалаар Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд хуулийн төслийн найруулгын үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг сайжруулан боловсруулахаар хуульчдын багийг ажиллуулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар ажиллаж байна.	70
			1,5 тэрбум	Эрсдэлт нөхцөлд амьдарч буй	- ХГБХХЕГ-ын даргын 2024 оны А/13 тоот тушаал, удирдамж баталж, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлж, мэдээллийн санд бүртгэх, бүртгэсэн хүүхэд түүний гэр бүлд шаардлагатай үйлчилгээг төлөвлөн, үр	70

				<p>хүүхдийн 70 хувьд урьдчилан сэргийлэх үйлчилгээ, хамгаалал шаардлагатай хүүхдэд хариу үйлчилгээг 100 хувь үзүүлсэн байна.</p>	<p>дүнтэй үзүүлж, эргэн хяналтыг тогтмолжуулж, эрсдэлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг 21 аймаг, нийслэл 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хэлтсийн дарга нарт даалгасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2024 оны эхний хагас жилийн байдлаар эрсдэлийн программд бүртгэлтэй 21783 хүүхэд байгаагаас 2024 онд шинээр 1113 хүүхдийг эрсдэлийн программд бүртгэн, хүүхэд түүний гэр бүлд Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын дагуу шаардлагатай үйлчилгээг үзүүлэн эрсдэлийг бууруулсан.</li> <li>- Түүнчлэн 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 147 хараа хяналтгүй хүүхдийг илрүүлж, эрсдэлийн программд бүртгэж, аюулгүй байдлыг ханган, шаардлагатай хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.</li> <li>- Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн тушаал удирдамжийг батлан 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар /хэлтэст хүргүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.</li> <li>- 2024 оны хагас жилийн байдлаар 1113 эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, 147 хараа хүүхдийг илрүүлж, мэдээллийн санд бүртгэн шаардлагатай үйлчилгээг үзүүлж, эрсдэлийг бууруулсан.</li> </ul>	
			221,8 сая	<p>Гэр бүл, хүүхэд, залуучууд ахмад настны хөгжлийн цогц төвийн үйлчилгээг нийт хүн амын 10-с доошгүй хувьд хүргэсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага стандарт /MNS 7038:2024/-ыг Стандарт хэмжил зүйн газрын 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 0/12 дугаар тушаалаар батлуулан стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймаг, нийслэл, дүүргүүдэд 33 төвүүд “Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв” -үүд нь гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга эзэмшүүлэх, угийн бичиг хөтлөх, зан үйлд нөлөөлөх чиглэлээр сургалт, хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулж, 2024 оны хагас жилийн байдлаар гэр бүлийн боловсрол олгох сургалтын 8 модулийн 24 сэдвийн хүрээнд зохион байгуулж, 55704 иргэнийг хамруулсан.</li> <li>- Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд 5-18 насны нийт хүүхдийн 12 хувь нь хамрагдаж байна. Улсын хэмжээнд бүртгэлтэй 58 зуслан байгаагаас 50 зуслан үйл ажиллагаа явуулж байна. 2023 онд 73,964 хүүхэд, 2024 онд 06 дугаар сарын байдлаар Хүүхдийн зуслангийн өвлийн болон улирлын ээлжид 28359 хүүхэд хамрагдсан. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 180 хүүхэд тусгай ээлжээр, зорилтот бүлгийн 145 хүүхэд тусгай ээлжид хамруулсан.</li> <li>- Улсын хэмжээнд Хүүхдийн ордон 15, Хөгжлийн төв 6, Хүүхдийн театр 4 ажиллаж, 2023 онд нийт 56,532 хүүхдэд хөгжлийн үйлчилгээ үзүүлсэн бол 2024 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар Хөгжлийн ордон, төв, театраар дамжуулан хөгжлийн үйлчилгээ авсан 48051 хүүхэд байгаагийн 21656 нь эрэгтэй, 26395 нь эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 175 байна.</li> </ul>	70
5	2.3.4. Орлогын тэгш бус байдлыг багасган нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэж, нийгмийн	2020 - 2050	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	<p>Хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлын дүн шинжилгээ</p>	<p>Эдийн засаг, хөгжлийн яам нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулан 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон. Уг хөтөлбөрийн хүрээнд Орлогын тэгш бус байдлыг багасган нийгмийн суурь</p>	50

		зорилтот болон ялгаатай бүлгүүдийн эрх, тэгш оролцоог хангана.			хийгдсэн байна.	үйлчилгээг тэгш хүргэж, нийгмийн зорилтот болон ялгаатай бүлгүүдийн эрх, тэгш оролцоог хангах асуудлыг тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.	
6		2.3.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.	2020 - 2050	12.6 тэрбум Дэлхийн банк	20.0 тэрбум	<p>Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.</p> <p>2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 881 иргэнд 20.2 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгож 1859 ажлын байрыг бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1006 иргэн, 118 аж ахуйн нэгжид 24.1 тэрбум төгрөгийн зээлийг олгож 2207 ажлын байрыг бий болгож, хадгалсан байна.</p> <p>Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/65 дугаар тушаалаар “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж”-ийг баталсан бөгөөд уг удирдамжид заасны дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэдэд Дэлхийн банкны санхүүжилтээр /13.0 тэрбум төгрөг/ цар тахлын дараах сэргэлтэд зориулсан бага хүүтэй, жижиг зээлийг 2024 оны 6 дугаар сараас эхлэн олгохоор дамжуулан зээлдүүлэх банкуудыг сонгон шалгаруулаад байна. Уг зээлийг 21 аймагт жилийн 6.0 хувь, Улаанбаатар хотод жилийн 8.4 хувийн хүүтэй Хаан банк, Төрийн банкуудаар дамжуулан олгох юм.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өөрийн эх үүсвэрээс олгосон жижиг зээлийн хүүгийн хэмжээг Дэлхийн банкны санхүүжилтээр олгож буй жижиг зээлийн хүүг тооцох аргачлалтай адилаар 2018-2020 оны инфляцийн түвшний дундаж /5.2%/ болон захиргааны холбогдох зардал, эрсдлийн хувийг тооцон /0.2%/ эх үүсвэрт тооцох хүүг жилийн 5.40 хувиар тогтоож, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/128 дугаар тушаалаар баталсан.</p> <p>Гэвч Монгол Улсын Засгийн газраас баталсан "ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛЖ ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ"-нд тусгагдсан "АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ 3 ХУВИЙН</p>	90

					<p>ХҮҮТЭЙ ЗЭЭЛ"-ийг олгож эхэлснээс хойш Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй жижиг зээлийн эрэлт харьцангуй багассан тул цаашид иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид олгох жижиг зээлийн хүүг аль болох бага түвшинд байлгах шаардлага үүссэн.</p> <p>Үүнтэй холбоотойгоор банкуудад санал болгох хүүгийн дээд хэмжээг Монгол Улсын 2016-2020 оны инфляцийн түвшний дундажтай уялдуулж банкнаас иргэдэд хүрэх зээлийн нийт хүү Улаанбаатар хотын 9 дүүрэгт 8.9 хувиас бага, хотоос хөдөөд шилжих бодлогын хүрээнд 21 аймагт 4.5 хувиас бага байх саналыг тус яамнаас дэвшүүлсэн.</p> <p><b>ИНФЛЯЦИЙН ЖИЛИЙН ТҮВШИН</b>, оны эцэст, хувиар:</p> <table border="1"> <tr> <td>ҮЗҮҮЛЭЛТ</td> <td>2016</td> <td>2017</td> <td>2018</td> <td>2019</td> <td>2020</td> </tr> <tr> <td>Инфляцийн түвшин</td> <td>1.3</td> <td>6.4</td> <td>8.1</td> <td>5.2</td> <td>2.3</td> </tr> </table> <p>Улмаар дээрх саналыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2022 оны а/203 дугаар тушаалын 2 дах хэсэгт заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/177 тоот тушаалаар байгуулагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банк сонгон шалгаруулах үнэлгээний хороо”-ны 2022 оны 12 сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцэн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ийн хүрээнд 2022 оны А/93 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банк сонгон шалгаруулах удирдамжид заасны дагуу банкинд байршуулах жижиг зээлийн хөрөнгийн нийт эх үүсвэр болон үлдэгдэл эх үүсвэрийн хувь, хэмжээг 4.4 хувь байхаар шийдвэрлэсэн.</p>	ҮЗҮҮЛЭЛТ	2016	2017	2018	2019	2020	Инфляцийн түвшин	1.3	6.4	8.1	5.2	2.3	
ҮЗҮҮЛЭЛТ	2016	2017	2018	2019	2020													
Инфляцийн түвшин	1.3	6.4	8.1	5.2	2.3													
7	2.3.6. Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2050	Дэлхийн банкны 4500\$	<p>Төрийн захиргааны мэдээлэл солилцох боломжийг судалсан байна. Судалгаа хийсэн байна. Судалгааны үр дүнд бүрдсэн мэдээллийн сангийн</p>	<p>Монгол Улсын Их Хурлаас 2012 онд шинэчлэн баталсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнийг тодорхойлох аргачлалыг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо хамтран батлахаар заасан. Үүний дагуу манай улс орлогыг орлуулан тооцох арга (ООТА)-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал (ӨАТТА)-ыг 2010, 2013, 2016 онуудад боловсруулан халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага ҮСХ-той хамтран баталж, өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлон улсын хэмжээнд өрхийн амьжиргааны түвшингээр эрэмбэлсэн мэдээллийн санг бүрдүүлж бодлого, хөтөлбөрт ашиглаж ирсэн юм.</p> <p>Энэхүү аргачлалыг хамгийн сүүлд Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хамтарсан А/84, А/89 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Уг</p>	90												

				мэдээллийг бодлого хөтөлбөрт ашиглаж эхэлсэн байна.	<p>аргачлалын гол онцлог нь өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц, орлогыг орлуулан тооцох боломжтой төрийн байгууллагын мэдээллийг ашиглаж өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан нийт хүүхдийн 91 хувьд олгохдоо өрхийн мэдээллийн нэгдсэн сан болон төрийн мэдээллийн бусад санг ашиглан бүрдүүлэхээр шийдвэрлэсэн. Ингэснээр өмнөх батлагдсан аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулж “Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-ыг нэмж тусган Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/14, А/04 дүгээр хамтарсан тушаалаар баталсан юм.</p> <p>Уг аргачлалын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/36 тоот тушаалаар улсын хэмжээнд орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг зохион байгуулах удирдамжийг баталсан.</p> <p>ООТА-аар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 26,900 өрхийг хамруулсан бөгөөд улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн ХХҮГ/ХХҮХ-ийн дарга, мэргэжилтэн болон судалгааны багийн гишүүдэд программ хангамжийн сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулсан.</p> <p>Судалгаанд нийт хамрагдах өрхийн 99.1% хамрагдсан тул цаашид төрийн бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлж ажиллах юм.</p>	
8	2.3.7. Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ.	2020 - 2050	2023 оны 01 сарын өдрөөс хэрэгжинэ.	<p>Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ өөрчлөгдөж байгаатай холбогдуулан emongolia болон ehalamj систем дээрх хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээний хэсгийг өөрчлөх ажлын даалгавар боловсруулах, туршилт хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг 2021 оны 11 сард баталж, Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд мөнгөн хуримтлал үүсгэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэлбэрээр хэрэгжих боломж бүрдсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ыг баталсан. Уг журмын дагуу Монгол Улсын иргэн 18 нас хүрснээр Хүүхдийн мөнгөн хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах бөгөөд энэ хүртэлх хугацаанд хуримтлалыг Төрийн сан дахь “Хүүхдийн мөнгөн хуримтлал”-ын дансанд хуримтлуулах ба дансны үлдэгдэлд хүү тооцох юм. 2022 оны 12 дугаар сарын байдлаар 31.6 мянган хүүхэд мөнгөн хуримтлал үүсгэсэн байна. Харин хүүхдийн мөнгөн хуримтлалаас 1,260 мянган хүүхдэд 100.0 мянган төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгосон байна.</p>	100	



					<p>2023 оны 1 дүгээр сараас нийт хүүхдийн 91 хувь, 7 дугаар сараас Монгол Улсын 0-18 насны бүх хүүхдэд хүүхдийн мөнгийг олгож байна. Хүүхдийн мөнгийг асрамжийн газарт өсч хүмүүжиж байгаа хүүхдүүд хүүхдийн мөнгөний тодорхой хувийг өөрсдийн хэрэгцээт зүйлс, дугуйлан секц зэрэг хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулах боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг холбогдох журамд тусгасан.</p> <p>Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын ядуурлын түвшинг 2 жил тутамд зарладаг бөгөөд энэхүү ядуурлын түвшинтэй уялдуулан Орлогыг орлуулан тооцох аргачлалыг шинэчлэх бүрдээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг шинэчлэн тогтоон хэрэгжүүлж ирсэн.</p> <p>Монгол Улсын ядуурлын түвшин 27.8 байсан бөгөөд энэ үед нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн - иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 409.679 ба түүнээс доош оноогоор тогтоож Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, Хууль зүйн өмгөөллийн үйлчилгээ, онцгой тохиолдлын тэтгэмжийг олгох зэрэг үйлчилгээнд ашиглаж байсан.</p> <p>Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны дүнгээр Монгол Улсын ядуурлын түвшин 2022 онд 27.1 хувьтай байгаа тул түүнд харгалзах оноог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/97 дугаар тушаалаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох босго шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 401.2 оноо болон түүнээс оноогоор тогтоож шинэчлэн батлан хэрэгжүүлж байна.</p>	
9		2.3.8. Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2020 - 2050	803.9 сая	<p>Нийт залуучуудын 45 хувийг залуучуудын хөгжлийн үйлчилгээнд хамруулна.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/107 дугаар тушаалын хүрээнд 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Олон Улсын хүүхдийн найрамдал цогцолборт 18 аймаг, өмнөговь аймгийн 14 сумын Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүд болон 21 аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /нийгмийн бодлогын хэлтсийн дарга/-аас бүрдсэн 67 үүрэг хүлээгчдэд залуучуудын хөгжлийн бодлого, үйл ажиллагааг ойлгуулах, хуулийн хүлээсэн 7 нэр төрлийн үйлчилгээг үзүүлэх арга зүйг хүргэлээ.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар 17 аймгийн Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан нийт давхардсан тоогоор 55708 өсвөр үе, залуучууд үйлчилгээ авч, 299 залууд ганцаарчилсан, 2565 залууд бүлгээр зөвлөгөө өгч, 1050 залууг тулгамдсан асуудлын хүрээнд холбогдох байгууллагад холбон зуучилж, 21667 залууд амьдрах ухаан болон бусад модульт сургалт зохион байгуулж, 739 залуучуудын сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг аргазүйгээр ханган, хамтран ажиллаж, нөлөөллийн 331 үйл ажиллагааг зохион байгуулсан байна.</p>	90

10		2.3.9. Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажил, ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих)	2020 - 2050		2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/- аар зохицуулсан. 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдсөн байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-т ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой тохиролцож болохоор заасан. Мөн 66 дугаар зүйлд Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, 67 дугаар зүйлд Гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ, 68 дугаар зүйлд Зайнаас ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ зэргийг тусгасан. Тус хуулийн 85 дугаар зүйлд Ажлын цагийг богиносгох нөхцөлийг заасан бөгөөд 85.1.2-т жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй ажилтны ажлын цагийг богиносгохоор эмнэлгийн магадалгаа гарсан, 88.5 Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол шөнийн цагаар ажиллуулахыг хориглоно. 91.4.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол илүү цагаар ажиллуулахыг хориглоно; 98.2.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй, эсхүл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулахыг хориглоно гэсэн заалт тусган батлуулж мөрдөж байна. Мөн 135 дугаар зүйлд Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахыг хориглох, 136 дугаар зүйлд Хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлага, олговор олгох,137 дугаар зүйлд Жирэмсний болон амаржсаны амралт, эцгийн чөлөө, 138 дугаар зүйлд Нярай хүүхэд үрчлэн авсан ажилтанд чөлөө олгох, 139 дүгээр зүйлд Хүүхэд асрах чөлөө олгох, 141.1.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтныг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулахыг хориглоно зэрэг заалтыг тусган батлуулан, мөрдүүлж байна.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-т ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой тохиролцож болохоор заасан.	90
11		2.3.10. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны хөдөлмөрийн бирж” байгуулж хөгжүүлнэ.	2020 - 2050	1,030.0 мянган төгрөг	Цагийн ажил хийх хүсэлтэй оюутан залуучуудыг 85-аас доошгүй хувийг цагийн ажлын байранд	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дэргэдэх Цагийн хөдөлмөрийн биржээр дамжуулан оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 975 ажил олгогчийн 1935 ажлын байрны захиалга ирүүлж, дараах байдлаар үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд: • Ажлын байрны захиалгын тоо: Нийт 1935 (цагийн ажлын байр 999, байнгын болон түр ажлын байр 936) • Ажлын байрны захиалгад бүртгүүлсэн ажил хайгч: Нийт 7838 иргэн (цагийн ажилд 673, байнгын болон түр ажлын байранд 6934, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 231)	

				<p>зуучилсан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажлын байр санал болгосон: 2829</li> <li>• Ажилд зуучлагдсан: 2052 (цагийн ажилд 712, байнгын болон түр ажлын байранд 1295, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 45)</li> <li>• Шинэ ажлын байр: 1935</li> <li>• Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээлээр хангах үйлчилгээнд хамрагдсан 1881 (ганцаарчилсан 1048, бүлгээр 833) оюутан, залуучууд ажил хайгч иргэд, зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл зөвөлгөө өгч, байнгын болон түр цагийн ажлын байранд зуучлагдан ажилласан байна.</li> </ul> <p>Цагийн хөдөлмөрийн биржээр дамжуулан оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг 10 аймаг, нийслэл, 4 дүүрэгт 53 хувьтай хэрэгжүүлж, санхүүжилт олгогдсон. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас санал авч төсөвт суулгадаг бөгөөд 2024 онд нийт 66.7 сая төгрөг зарцуулахаас 51.5 сая төгрөгийг нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар зарцуулсан. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар дийлэнх төсвийг авч хэрэгжүүлдэг нь Их, дээд сургууль болон мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүд Улаанбаатар хотод төвлөрсөнтэй холбоотой байна. Хөдөө орон нутагт нийт 458 иргэнийг цагийн ажилд зуучлах арга хэмжээнд хамруулж, 4.7 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>Түүнчлэн Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “In Business” модулийн дагуу хөдөлмөрийн харилцаа, холбогдох хууль тогтоомжийн мэдлэг олгох сургалтыг ажил олгогч байгууллагуудтай хамтран Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвүүдэд зохион байгуулж, бизнес эрхлэх сонирхолтой 135 хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан суралцагчдыг хамрууллаа.</p> <p>Мөн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн оюутан суралцагчдад зориулан “Student day-2024” уулзалтад хууль тогтоомжид тусгагдсан цагийн ажил, бүтэн бус цагийн хөдөлмөрийн зохицуулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, төлөв байдлын талаарх мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>“Хөдөлмөр, эрхлэлт 2024” өдөрлөг арга хэмжээг Олон Улсын хөдөлмөрчдийн өдрийг тохиолдуулан Мишээл Экспо төвд 5 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.</p> <p>Тус өдөрлөгөөр орчин цагийн хөдөлмөрийн харилцааны чиг хандлагад нийцүүлэн оюутан залуучууд, иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхол, сэдлийг төрүүлэх, тэдний бүтээлч санаа, инновацыг сурталчлах арга хэмжээтэй өдөрлөгт оролцогчид өртөөчилсөн байдлаар танилцах боломж бүрдүүлснээрээ тус арга хэмжээ онцлог боллоо. Тухайлбал, Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа, Залуучуудын старт ап, дижитал төслийн үзэсгэлэн, Ур чадварыг үнэлэх үйлчилгээ, мэдээлэл зөвлөгөө, Залуучууд-Зохистой хөдөлмөрийн мэдлэг, мэдээлэл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөгөө, мэдээлэл, гадаад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөгөө мэдээлэл, ажил</p>	90
--	--	--	--	---	----

					<p>олгогчдын нээлттэй ажлын байр, нийгмийн халамжийн зөвлөгөө мэдээлэл гэсэн өртөөнүүд ажилласан юм.</p> <p>Мөн Хөдөлмөрийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/123 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журмын төслийг шинэчлэн боловсруулж байна.</p> <p>Журмын төсөлд Монголын ахмадын холбооноос хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, хувийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг оновчтой болгох, санхүүжилт, зарцуулалтад хяналт тавих талаар тусгасан болно.</p>	
12	2.3.11. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийн мэдээллийн сан бүрдүүлж, тэднийг иргэний эрхээ эдлэх боломж, нөхцөлийг техник, технологийн ололтод тулгуурлан бүрдүүлж, эх орондоо чиглэсэн бизнесийн болон сайн дурын үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээ хийх, эх нутагтаа эргэн ирж ажиллаж, хөдөлмөрлөхөд дэмжлэг болохуйц эрх зүйн орчныг бүрдүүлж, цахим хөдөлмөрийн бирж, мэдээллийн систем ажиллуулна.	2020 - 2050	-	-	<p>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх заалтуудыг тусгаж өгсөн. Тухайлбал тус хуулийн 20 дугаар зүйлд “Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх” тухай зохицуулалтыг тусгасан болно. Эх орондоо буцаж ирсэн монгол ажилтанд ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, хөдөлмөр эрхлэхэд хууль тогтоомжид заасны дагуу дэмжих, төсөл, хөтөлбөрт хамруулах дэмжлэг үзүүлнэ. Энэхүү үйл ажиллагааны санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, холбогдох Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан болно.</p> <p>Мөн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ийг шинэчлэн баталсан. Журмын 2.2-т зээл хүсэгч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан иргэн, аж ахуйн нэгж байх бөгөөд нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн нь байгуулж буй нөхөрлөл, хоршоогоо Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхээр мэдүүлсэн иргэдийн эрх бүхий төлөөлөгч, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн нь гадаад улсад суралцахаас бусад зорилгоор ажиллаж, амьдарч байгаад эх орондоо буцаж ирээд 48 хүртэл сар болж байгаа иргэн байх бөгөөд 25 хүртэлх сая төгрөг байна.</p> <p>Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол улсын иргэд эх орондоо чиглэсэн бизнесийн болон сайн дурын үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээ хийх, эх нутагтаа эргэн ирж ажиллаж, хөдөлмөрлөхөд дэмжлэг болохуйц Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн.</p> <p>“Ejob” платформд гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол иргэдэд зориулсан сан бүхий хэсэг, хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) модуль хэсгийг шинэчлэн хөгжүүлж, цахим өдөрлөг яармаг зохион байгуулах зэрэг эх орондоо эргэн ирж ажиллах нөхцөл бололцоог ханган ажилд зуучлах, ажил хайх үйлчилгээг онлайн хэлбэрээр авч болохоор программ хангамжийн хөгжүүлэлт хийгдсэн болно.</p>	100

					<p>Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын холбогдох яамтай хамтран “Хөгжлийн албан ёсны буцалтгүй тусламж/Official Development Assistance-ODA”-аар 2024-2025 онд санхүүжин хэрэгжих “Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжих нь” төслийг боловсруулан Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт асуулга, мэдээллийг БНСУ-ын холбогдох яаманд бэлтгэж хариуг хүргүүлж ажилласан. Төсөл хэрэгжүүлэхэд БНСУ-ын холбогдох яамнаас хариу хүлээж байгаа болно.</p> <p>Түүнчлэн “Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших” Монгол иргэдэд чиглэсэн Засгийн газраас арга хэмжээний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх асуудлаар санал гаргах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Үндэсний хороог ЗГ-ын 2024 оны 70 дугаар тогтоолоор байгуулсан. Уг Үндэсний хорооны даргаар Гадаад харилцааны сайд, дэд даргаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тус тус ажиллаж байна.</p> <p>Цаашид Үндэсний хорооноос дэд ажлын хэсэг байгуулахаар төлөвлөж байгаа болно.</p> <p>Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон <b>гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэдэд</b> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өөрийн эх үүсвэрээс 20.2 тэрбум төгрөгийн бага хүүтэй, жижиг зээлийг 881 иргэнд олгосны үр дүнд нийт 5210 ажлын байрыг шинээр бий болгож, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна. Зээлийг олгоходоо хотоос хөдөөд шилжих бодлогын хүрээнд аймаг, орон нутагт жилийн 4.4 хувийн хүүтэй Төрийн банкаар, Улаанбаатар хотод жилийн 8.5-8.8 хувийн хүүтэй Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудаар дамжуулан зохион байгуулсан. 2024 онд Дэлхийн банкны санхүүжилтээр 13.0 тэрбум төгрөгийн жижиг зээлийг зорилтод бүлгийн иргэдэд олгоно.</p>	
13	2.3.12. Залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	2020 - 2050	23.1	<p>Гэр бүлийн боловсрол, олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг олон талын оролцоотой хөгжүүлж, нийт залуучуудын 45 хувийг, хамруулна.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар 17 аймгийн Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан нийт давхардсан тоогоор 55708 өсвөр үе, залуучууд үйлчилгээ авч, 299 залууд ганцаарчилсан, 2565 залууд бүлгээр зөвлөгөө өгч, 1050 залууг тулгамдсан асуудлын хүрээнд холбогдох байгууллагад холбон зуучилж, 21667 залууд амьдрах ухаан болон бусад модуль сургалт зохион байгуулж, 739 залуучуудын сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг аргазүйгээр ханган, хамтран ажиллаж, нөлөөллийн 331 үйл ажиллагааг зохион байгуулсан байна.</p> <p>Аймаг, нийслэл, дүүргүүдэд 33 төвүүд “Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв” -үүд нь гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга эзэмшүүлэх, угийн бичиг хөтлөх, зан үйлд нөлөөлөх чиглэлээр сургалт, хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулж, 2024 оны хагас жилийн байдлаар гэр бүлийн боловсрол олгох сургалтын 8 модуль 24 сэдвийн хүрээнд 55704 иргэнийг хамруулсан.</p> <p>“Гэр бүлийн боловсрол олгох сургалтын гарын авлага”-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-ГБХЗХГ болон МУИС-ийн Социологи, нийгмийн ухааны тэнхим, НЭМҮТ-ийн Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх алба, Олон улсын Улаанбаатарын Их сургуулийн Гэр бүл, сэтгэл судлалын тэнхим хамтран боловсруулж холбогдох мэргэжилтнүүдийг сургасан.</p>	90	

14	2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.	2.6.2. Байнгын ажил олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	2020 - 2050	25.7 тэрбум	2281 хүн	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/ хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг дэмжих, Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 үйл ажиллагааны 34 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дугаар тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээний хувийг ХХҮЕГ, ХБХХЕГ, ХНХСҮСИ-д тус тус хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг албан тоотоор мэдэгдсэн болно. ХХҮЕГ нь сар бүрийн 03-ны өдрийн дотор холбогдох тайлан мэдээг цаасаар болон цахимаар ирүүлж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 2024 оны хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 17.8 мянган хүн хамрагдаж 2.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээний хүрээнд 4.7 мянган ажлын байрыг бий болгож, хадгалснаас 3.3 мянга нь байнгын, 1.4 мянга нь түр ажлын байр байна.</p>	70
15		2.6.3. Ажлын байр олноор бий болгож байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулна.	2020 - 2050	200.0 сая  121.0 сая	50 ААНБ	<p>Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах зорилгоор “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан. Тус тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.1 дэх заалтад Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох, дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.4 дэх заалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэхээр тус тус заасан.</p> <p>Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн 4.3 дахь заалт “Нийгмийн хариуцлагатай хувийн хэвшил, төрийн байгууллага, нөхөрлөл хоршоог шалгаруулна гэж заасны дагуу оны төгсгөлд сонгон шалгаруулдаг болно.</p>	90

				110 ААНБ	<p>/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.2 зааснаар ажил олоход хүндрэлтэй иргэн нь үндсэн ажилтнаар 1 жилээс доошгүй хугацаанд ажиллахаар заасан/.</p> <p>2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд тусгагдсан Ажил олоход хүндрэлтэй иргэнийг урт хугацаанд тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчид цалингийн дэмжлэг үзүүлэх тухай" арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцээд тусгайлсан хөтөлбөр боловсруулан батлуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллах тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгын хамтаар боловсруулсан. Ажил олоход хүндрэлтэй иргэнийг тогтмол ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд тусгайлсан журам боловсруулах шаардлагатай байгаа тул Ажил олгогчийг дэмжих туршилтын төслийн журмыг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд 2023 оны 6 дугаар сард танилцуулсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг дахин хэлэлцүүлж ХЭҮЗ-ийн тогтоол гаргуулсан. Энэ дагуу "Ажил олоход хүндрэлтэй иргэнийг урт хугацаанд тогтвортой ажлын байраар хангах ажил олгогчид цалингийн дэмжлэг үзүүлэх зорилготой "Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөл"-ийн талаарх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын гишүүдэд танилцуулсан. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны хурлаар Ажил олгогчийг дэмжих туршилтын төслийг эцэслэн ХЭҮЗ-ийн 8 дугаар тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>"Ажил олоход хүндрэлтэй иргэнийг урт хугацаанд тогтвортой ажлын байраар хангах ажил олгогчид цалингийн дэмжлэг үзүүлэх зорилготой "Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөл"-ийн танилцуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 27-ны хурлаар Ажил олгогчийг дэмжих туршилтын төслийг эцэслэн ХЭҮЗ-ийн 8 дугаар тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Туршилтын төсөлд хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний дагуу хөдөлмөрийн зах зээлд гарахад бэлэн, ажлын байран дээр дагалдан ажилтнаар 3 ба түүнээс дээш сарын хугацаанд дадлагажин хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангах ажил олгогчид:</p>
--	--	--	--	----------	---

					<p>- Улаанбаатар хотод ажил олоход хүндрэлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид ердийн дагалднаар ажиллах 5 сарын хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц цалингийн дэмжлэг;</p> <p>- Ажил олоход хүндрэлтэй иргэнийг аймагт байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид ердийн дагалднаар ажиллах 5 сарын хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 хувиар нэмэгдүүлсэнтэй тэнцэхүйц цалингийн дэмжлэг;</p> <p>- Ажил олоход хүндрэлтэй иргэнийг эдийн засгийн тэргүүлэх салбарт байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид ердийн дагалднаар ажиллах 5 сарын хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 хувиар нэмэгдүүлсэнтэй тэнцэхүйц цалингийн дэмжлэгийг тус тус олгоно.</p> <p>Уг арга хэмжээнд нийт 5200 хүнийг хамруулахаар төлөвлөж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн болно. 2024 оны эхний хагас жилийн байдлаар Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөлд нийт 22 аж ахуйн нэгж байгууллагатай 88 дагалдан ажилтан тогтвор суурьшилтай ажиллахаар гэрээ байгуулж ажиллаж байна. Уг арга хэмжээнд нийт 5200 хүнийг ирэх оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд хамруулахаар төлөвлөж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн болно.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөлд нийт 20 аж ахуйн нэгж байгууллага 25 мэргэжлээр 88 дагалдан ажилтан тогтвор суурьшилтай ажиллаж байна.</p>	
16	2.6.4. Ажлын байрны мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулна.	2020 - 2050	70.0 сая	Динамик загварын хөгжүүлэлт	<p>Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загварын хөгжүүлэлтийн ажлын хүрээнд эдийн засгийн салбаруудыг мал аж ахуй, газар тариалан, худалдаа үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилгын үйлдвэрлэл, уул уурхайн үйлдвэрлэл, дулаан ба цахилгаан үйлдвэрлэл гэсэн 7 салбараар симуляци хийхийн тулд Кобба-Дугласын үйлдвэрлэлийг функцийг ашигласан. 2050 хүртэлх хугацааны дараах таамаглалуудыг тооцоолсон байна. Тухайлбал, Монгол Улсын хүн ам, дундаж наслалт, 1 хүнд ноогдох ДНБ, нийт ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин, тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага, тэтгэврийн даатгалын сан, тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого, тэтгэврийн даатгалын сангийн бусад орлого, албан журмаар даатгуулагчид, сайн дурын даатгуулагчид, тэтгэвэр авагчийн тоо, цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчийн тоо, ҮОМШӨ-ний тэтгэвэр авагчийн тоо, өндөр насны тэтгэвэр авагчийн тоо зэрэг болно. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн, аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын шимтгэлийн зохист хэмжээг тооцоолох, судалгаа, динамик аппликейшн</li> <li>2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, инфляцийг амьжиргааны баталгаажих доод түвшинтэй холбож тодорхойлох</li> <li>3. Төмөр замын төслийн хөрөнгө оруулалт нь бодит ДНБ, ажилгүйдлийн түвшин, уул уурхайн салбарт үзүүлэх нөлөөлөл симуляц,</li> <li>4. 2028 он хүртэлх таамаглал НД-ын орлого, зарлагын симуляц</li> <li>5. Тэтгэврийн нас нэмэгдүүлэх симуляц</li> </ol>	90



						Хөдөлмөрийн насны иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ур чадвар олгох сургалт ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөө юм.	
17		2.6.5. Дотоодын нийт бүтээгдэхүүнд цалин болон түүнтэй тэнцэх орлогын эзлэх хувиар шалгуур үзүүлэлт болгон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрэх үр дүнг тогтооно.	2020 - 2050	155.3 тэрбум төгрөг	Төрийн албан хаагчдын сарын дундаж цалин 1296.1 мян.төг	<p><b>1/ 2022 онд:</b> Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоосон. Үр дүнд нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс 8.5 хувиар нэмэгдсэн. Мөн Засгийн газрын 2022 оны 193 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах болон ТЗ-5 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг, төрийн захиргааны албан тушаалын АА-9 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүгчийн туслах болон АА-10 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоосон.</p> <p>Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөвт төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх замаар цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан тогтоодог болох, төрийн албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хувь хэмжээгээр нэмэгдүүлэх дараах арга хэмжээ тусгагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албаны цалингийн олон шатлал, зэрэглэлийг цэгцлэн үндсэн цалинг шатлалгүй болгож, төрийн захиргааны 15 зэрэглэлийг 10 болгоно.</li> <li>• Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлнэ.</li> <li>• Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах хүрээнд орон нутгийн нэмэгдэл олгоно. Ингэхдээ улсын төсвөөс 20 хувийн нэмэгдлийг олгох ба энэ хэмжээг 100 хүртэл хувьд хүргэх эрхийг орон нутагт нь олгоно.</li> <li>• Нийт төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дээшлүүлэх хүрээнд тэдний ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгодог болно.</li> <li>• Төрийн захиргааны албан хаагчдын хариуцлага, ажлын үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн удирдах албан тушаалтнуудыг ажлын үр дүнгээр нь, төрийн гүйцэтгэх албан тушаалтнуудыг гүйцэтгэлээр нь үнэлдэг болно.</li> </ul> <p>Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны улсын төсвийн төсөлд нийт 266.2 тэрбум төгрөг тусгасан.</p> <p><b>2/ 2023 онд:</b> Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дунджаар <b>40 хувиар</b> нэмэгдүүлэн тогтоолоо. Уг арга хэмжээний хүрээнд: Төрийн захиргааны албан хаагчдын болон шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, биеийн тамир, спортын салбарын төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээг 1.0 сая төгрөгт хүргэлээ. Мөн төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг</p>	100

					<p>бүхий нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 750.0 мянган төгрөг болсон. Энэхүү арга хэмжээний үр дүнд шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 47.0 хувиар, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 52.0 хувиар, бага, дунд боловсролын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 30.0 хувиар, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 51.0 хувиар, соёл, урлагийн салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 64.0 хувиар, биеийн тамир, спортын салбарын албан хаагчдын үндсэн цалин дунджаар 58.0 хувиар тус тус нэмэгдлээ. Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин 26.0-31.0 хувиар нэмэгдсэн (2023 оны 1 дүгээр сарын 01-нээс 8 хувиар нэмэгдсэн).</p> <p><b>3/ 2024 онд:</b> Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүллээ. Мөн хөдөөгийн суманд ажиллаж байгаа 51.8 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувь, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа 53.4 мянган төрийн албан хаагчид сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдлийг нийт 105.2 мянган төрийн албан хаагчид олгохоор болсон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 1.1 сая төгрөг (Суманд 1,540.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,320,0 мянган төгрөг), төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 900.0 мянган төгрөг (Суманд 1,260.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,080.0 мянган төгрөг) боллоо. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ажиллагчдын дундаж цалин хөлс 2,235.4 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс 2,162.2 мянган төгрөг байна.</p>	
18	2.6.6. Гэр бүлийн анхдагч хэрэгцээг цалин, орлогынхоо 50 хувиар хангахаар тооцож цалингийн тогтолцоог шинэчилнэ.	2020 - 2050	-	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550.0 мянган төгрөг	<p>Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 3273 төгрөг 80 мөнгө буюу сард 550,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.</p>	100
19	2.6.7. Иргэдийн цалин, урамшууллыг тогтмол нэмэгдүүлэхэд	2020 - 2050	140.0 тэрбум төгрөг	Ажиллагчдын сарын дундаж цалин 1544.4 мян.төг	<p>Цалин хөлс нь ажилтан болон ажил олгогчийн хоорондын сонирхлын тэнцвэрийг хангах, ажилтныг идэвхжүүлэх, сэдэлжүүлэх замаар ажлын байранд нь тогтвор суурьшилтай ажиллуулах гол механизм юм. ХНХЯ-наас "Цалин хөлс тогтоох аргачлал", "Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа</p>	70

		компанийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрийг дэмжин урамшуулна.				ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал"-ыг тус боловсруулан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 болон 6 дугаар тогтоолоор тус тус батлууллаа. Дээрх аргачлал нь аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд цалин хөлс тогтоох, нэмэгдүүлэхэд үндэслэх арга зүйн гол хэрэгсэл юм. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор "Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр" батлагдаж, Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2024 оны төсвийн хуваарийн 3.5.1-ийн 6 дугаарт уг хөтөлбөрийн зардал 968,1 сая төгрөг тусган батлагдсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Мэргэшсэн зөвлөх"-үүдийг бэлтгэх сургалтыг 2024 оны 05 дугаар сард зохион байгуулсан. Тус хөтөлбөрийг сурталчлан танилцуулах, хамрагдах хүсэлтэй аж ахуйн, нэгж байгууллагыг судалгааг гарган хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.	
20		2.6.8. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, "Хиймэл оюун ухаан ба ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2020 - 2050	75 сая Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа	75 сая Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа"-г жил бүр хийж, нийтэд мэдээлж байгаа бөгөөд энэхүү судалгаа нь хөдөлмөрийн зах зээлийн богино хугацаа буюу дараа жилийн ажиллах хүчний хэрэгцээ, мөн өнгөрсөн жилийн хугацаан дахь ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, байршлаар тодорхойлж, санал зөвлөмж боловсруулдаг. Судалгааны дүнгээр улсын хэмжээнд 2024 онд нийт 95.3 мянган ажлын байранд ажилтан авах хэрэгцээ бий болох ба өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 10.0 гаруй мянган ажлын байр буюу 12.7 хувиар өсөж, хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий чиг хандлага хадгалагдах төлөв ажиглагдсан төдийгүй сүүлийн 10 жил дэх хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Ажиллах хүчний эрэлт /шинэ/-ийн хүрээнд хөдөлмөр эрхлэлт 5.1 хувиар өсөх боломж байгаа нь харагдаж байна. 2024 онд ажиллах хүчний эрэлт хамгийн их байх салбар нь бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбар болж байна. Бөөний болон жижиглэн худалдааны салбарт жилийн нийт эрэлтийн 31.3 хувь буюу 29.8 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь өмнөх оны үр дүнгээс 35.5 хувиар өсөх үзүүлэлттэй байна. Барилгын салбарт 15.3 мянган ажиллах хүчний эрэлт бий болж нь нийт эрэлтийн 16.0 хувийг эзэлж, өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 14.9 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 14.0 мянга буюу нийт эрэлтийн 14.7 хувь бий болж, 47.6 хувиар өсөх үзүүлэлттэй байна. Энэ оны /2024/ хүлээгдэж буй ажиллах хүчний нийт эрэлтийн 29.6 хувь нь орон нутагт бий болох төлөвтэй бөгөөд үүний 65.2 хувь нь шинэ ажлын байр байна. Энэ нь орон нутгийн хөдөлмөрийн зах зээл тэлэх боломжтойг харуулж байгаа юм. Орон нутгийн ажиллах хүчний эрэлтэд дараах эдийн засгийн салбарууд гол нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбарт орон нутгийн ажиллах хүчний эрэлтийн 31.7 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 14.4 хувь, барилгын салбарт 12.8 хувь нь тус тус бий болох төлөвтэй байна. 2023 онд аж ахуйн нэгж байгууллагын 23.6 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах	90	

					<p>хүчний хомсдолд өртсөн гэсэн нь өмнөх оноос 7.7 пунктээр өссөн үзүүлэлт болжээ.</p> <p>Ажиллах хүчний хомсдолд өртсөн нийт ААНБ-уудын 40.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ажиллах хүчний хомсдолын 38.8 хувийг тухайн салбарын хомсдол эзэлж байна. Үүнээс гадна барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн аж ахуйн нэгжүүдийн 24.2 хувийг эзэлж, эдгээр салбарын ажиллах хүчний хомсдол нийт хомсдолын 29.7 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд өнгөрсөн жил зөвхөн дээрх 3 салбарын хүрээнд ажиллах хүчний хомсдолоос үүдэлтэй 33.4 мянган ажлын байр байжээ. Харин ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий агааржуулалтын салбар, уул уурхай, олборлолт, урлаг, үзвэр, тоглоом наадам салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн тохиолдолд эзлэх хувь хамгийн бага байна. Ажиллах хүчний хомсдолыг ажил мэргэжлийн бүлгийн хувьд авч үзвэл мэргэжилтэн, худалдаа, үйлчилгээний ажилтан, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, энгийн ажил мэргэжлийн бүлгүүдийн ажил мэргэжлийн ажиллагчдын хомсдол 75.5 хувийг бүрдүүлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.</p> <p>Тухайлбал, үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, барилгын туслах ажилтан худалдагч, цэвэрлэгч, үйлчлэгчийн ажлын байрууд болон засалчин, шаварчин, жолооч, оёдолчин, мужаан, тогооч, зөөгч, гагнуурчин, цахилгаанчин, сантехникч, нягтлан бодогч зэрэг эрэлттэй ажил мэргэжлийн хүрээнд нэрлэгдсэн ажил мэргэжлүүдийн хүрээнд хомсдол буюу ажиллах хүчний дутагдал үүссэн байна. Дурдагсан ажил мэргэжлүүдийн ажиллах хүчний хомсдолд эзлэх хувийн жин 47.4 хувь байна.</p>	
21	2.6.10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн салбар дундын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	2020 - 2050	-	-	<p>Манай яамнаас Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд 2035 он хүртэл шаардагдах эрэлттэй ажил, мэргэжлийн судалгааг олон улсын арга, аргачлалын дагуу хийхээр гадаад, дотоодын зөвлөх баг шалгаруулж, судалгааны ажлыг 2023 онд эхлүүлсэн. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн дунд хугацааны таамаглалыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөдөлмөрийн чиглэлээр мэргэшсэн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэгч байгууллагуудын арга аргачлал, загварыг харьцуулан судалж боловсруулсан. Уг судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт болон “Эм Эм Си Жи” ХХК-ийн зөвлөх үйлчилгээний багтай хамтран гүйцэтгэсэн.</p> <p>Энэхүү судалгааны үр дүнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх, боловсролын салбар болон хөдөлмөрийн зах зээлийн уялдааг хангах, макро, микро түвшин хоорондын харилцан үйлчлэлд дүн шинжилгээ хийх, бодлогын өөрчлөлт, эдийн засгийн шок, салбар хоорондын уялдаа холбоо, хөдөлмөр эрхлэлтийн үр нөлөөг үнэлэх суурь мэдээлэл болж, Монгол Улсын эдийн засгийн өсөлт болоод нийгэмд бодитой хувь нэмэр оруулах юм.</p> <p>Мөн хөдөлмөрийн зах зээлийн таамаглалын эцсийн үр дүнг 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, хуралдааны тэмдэглэл гаргуулсан болно. Түүнчлэн Засгийн газрын 6 дугаар хуралдааны</p>	90

						<p>тэмдэглэлийн дагуу тус судалгааг Улсын Их Хурал дахь Нийгмийн бодлогын байнгын хороо, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, төрийн бус байгууллагуудад тус тус танилцуулж уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус судалгааг англи хэл дээр орчуулан хэвлүүлж Олон Улсын байгууллагууд болон Гадаад харилцааны яам, Элчин сайдуудад хүргүүлсэн болно.</p> <p>Түүнчлэн эрхлэх асуудлын хүрээнд бусад чиглэлийн яам, холбогдох байгууллагуудтай хамтран албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэхэд цахим систем болон цахим үйлчилгээнүүдийг дэмжих, хэрэгцээ шаардлагад үндэслэн цахимаар албажуулах санал боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлаар албан бус эдийн засгийг бүртгэлжүүлэх, албажуулахад ашиглах системийн загвар /дизайн/ боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажиллаж байна.</p> <p>Үүний дагуу бодлогын зөвлөмж боловсруулахаар мэдээллийн технологийн болон ахлах зөвлөх сонгон шалгаруулан ажиллаж байна.</p> <p>Мэдээллийн технологийн болон ахлах зөвлөхүүд 2024 оны 5 дугаар сарын 21-30-ны өдрүүдэд холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцлаа.</p> <p>Энэ хүрээнд албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэхэд тохирох цахим системийг сонгох, төрийн мэдээллийн системүүдийн мэдээлэл солилцох боломж, технологийн бэлэн байдлыг судлан 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдөр холбогдох яамд, агентлаг, нийгмийн түншлэлийн байгууллагуудыг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн хүрээнд талуудаас гарсан санал, зөвлөмжид үндэслэн зөвлөхүүд энэ ондоо багтаан бодлогын зөвлөмжийг боловсруулж гаргах юм.</p>	
22	2.6.11. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим болон зайн ажлын байрыг нэмэгдүүлэн тогтолцоог нь дэмжиж хөгжүүлнэ.	2020 - 2050		Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022.01.01-с хэрэгжүүлж эхэлнэ.	УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ажилтныг гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах, бүтэн бус цагаар ажиллах, иргэд хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулах зэрэг зохицуулалт шинээр туссан. Ингэснээр ажилтан, ажил олгогч харилцан тохиролцон хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон уян хатан зохицуулалтыг хэрэглэх боломж бүрдсэн.	50	
23	2.6.13. Хүн амын бүлэг бүрийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.	2020 - 2050	59.7 тэрбум ХЭДС	40000 хүн	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нийт <b>17,872</b> иргэн хамрагдаж, <b>2,985,811,497</b> төгрөгийг зарцуулсан байна. Үйл ажиллагаа тус бүрээр авч үзвэл:	90	

					<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 14239 иргэн хамрагдаж, 269,088,222 төгрөгийг;</li> <li>• Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 1711 иргэн хамрагдаж, 113,561,520 төгрөгийг;</li> <li>• Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 437 иргэн хамрагдаж, 1,608,838,000 төгрөгийг;</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 359,090,806 төгрөгийг;</li> <li>• Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд 1485 иргэн хамрагдаж, 635,232,949 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</li> </ul> <p><u>Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд:</u> 2024 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр нийт 12,927 иргэн хамрагдаж 242,108,573 төгрөгийг зарцуулсан байна. Арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 9,846 иргэн хамрагдаж, 157,669,070 төгрөгийг;</li> <li>• Ажилд зуучлах үйлчилгээнд 3,081 иргэн хамрагдаж, 84,439,503 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</li> </ul> <p><u>Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд:</u> 2024 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 1711 иргэн хамрагдаж, 113,561,520 төгрөгийг зарцуулсан байна. Арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Суурь ур чадварын сургалтад 608 иргэн хамрагдаж, 36,471,000 төгрөгийг;</li> <li>• Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалтад 69 иргэн хамрагдаж, 31,222,200 төгрөгийг;</li> <li>• Аж ахуй эрхлэлтийн сургалтад 782 иргэн хамрагдаж, 23,912,500 төгрөгийг;</li> <li>• Залуучуудын сургалтын зөвлөгөөнд 120 иргэн хамрагдаж, 4,800,000 төгрөгийг</li> <li>• Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад 132 иргэн хамрагдаж, 113,561,520 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</li> </ul> <p><u>Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд:</u> 2024 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 437 иргэн хамрагдаж, 1,608,838,000 төгрөгийг зарцуулсан байна. Арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 81 иргэн хамрагдаж, 793,150,000 төгрөгийг</li> <li>• Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 23 иргэн хамрагдаж, 203,750,000 төгрөгийг;</li> <li>• Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 69 иргэн хамрагдаж, 506,500,000 төгрөгийг;</li> <li>• Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 4 иргэн хамрагдаж, 26,620,000 төгрөгийг;</li> <li>• Түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 260 иргэн хамрагдаж, 78,818,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</li> </ul>
--	--	--	--	--	--

					<p><u>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд:</u> 2024 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 359,090,806 төгрөгийг зарцуулсан байна. Арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд 41,649,400 төгрөгийг;</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 317,441,406 тус тус зарцуулсан байна.</li> </ul> <p><u>Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд:</u> 2024 оны 06 дугаар сарын байдлаар 1485 иргэн хамрагдаж, 635,232,949 төгрөгийг зарцуулсан байна. Арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мод тарих арга хэмжээнд 55 иргэн хамрагдаж, 35,202,000 төгрөгийг;</li> <li>• Нийтийг хамарсан ажил зохион байгуулахад 1397 иргэн хамрагдаж, 569,304,949 төгрөгийг;</li> <li>• Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 28 иргэн хамрагдаж, 27,900,000 төгрөгийг;</li> </ul> <p>Хүүхэд хамгаадагч үйлчилгээнд 5 иргэн хамрагдаж, 2,826,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p>	
24	2.6.14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	2020 - 2050	6 барилгын тооцоолол, зураг төслийг боловсруулж, батлуулсан байна.	<p>Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 6 аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Үүний дагуу 2022 онд Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл аймгийн барилгыг ашиглалтад авч, 2023 оны 9 дүгээр сард Дархан-Уул, Дундговь, Ховд аймгуудын, 2024 оны 3 дугаар сард Хөвсгөл аймгийн, 6 дугаар сарын 11-нд Дорнод аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн үйл ажиллагааг нээж, үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>ХНХ-ын сайдын 2022 оны А/159 дүгээр тушаалын дагуу төвийн бүтэц, үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байна.</p> <p>Архангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга гүйцэтгэл 50%-тай байна.</p>	70	
25	2.6.15. Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.	2020 - 2050	-	<p>Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талаар Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд тусгасан байна.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Засгийн газар шинэчлэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Эдгээр хуульд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль батлагдсан бөгөөд ажилгүйдлийн даатгалын харилцааг энэхүү хуульд нарийвчлан тусгаад байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль хэрэгжсэнээр тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх буюу ажилласан жилтэй уялдсан байх, нийгмийн даатгалын шимтгэлийн нийт хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр сан хооронд зохицуулалт хийснээр ажилгүйдлийн даатгалын сан орлогоороо зарлагаа нөхөх боломж бүрдэх, ажлын байраа хадгалсан, Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн</p>	90	

					хэмжээ нэмэгдэх, тэтгэмжийн даатгалын сангаас болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн харилцааг нэг зохицуулах зэрэг эерэг үр дүн гарах юм.	
26	2.6.16. Хүн амын бүлгүүд, тухайлбал эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.	2020 - 2050	-	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022.01.01-с хэрэгжүүлнэ.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-т ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой тохиролцож болохоор заасан. Мөн 66 дугаар зүйлд Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, 67 дугаар зүйлд Гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ, 68 дугаар зүйлд Зайнаас ажиллах ажилтны хөдө 144.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй; 144.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асардаг ажилтан хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч түүнд гэрээсээ, зайнаас, бүтэн бус цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжит арга хэмжээг авна. Хөдөлмөрийн гэрээ зэргийг тусгасан. 145.2.Ажилтан өндөр насны тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. 145.3.Ажил олгогч ахмад настны хүсэлтээр ажлын цагийг богиносгож, бүтэн бус цагаар ажиллуулж, эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна гэсэн заалт тусган батлуулан, мөрдөж ажиллаж байна.	100
27	2.6.17. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүний эрх, нийгмийн хамгааллын баталгаа бүхий орчин, нөхцөлд шийдвэрлэж, хүн амын аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна.	2020 - 2050	-	-	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх” гэж заасан.  Дээр дурдсан УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан, мөн “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн үйлчлэх хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсонтой тус тус холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 20-ны УИХ-ын нэгдсэн чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32.6-д “Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан тохиолдолд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гадаад	100



					<p>ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлж болно.” гэсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулж батлуулсан.</p> <p>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасны дагуу “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Монгол Улсад 2023-2025 онуудад шаардлагатай нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг аж үйлдвэрийн IV хувьсгал, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн динамик өөрчлөлт, олон улсын хөдөлмөрийн чиг хандлага болон өмнөх жилүүдийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажиллах хүчний статистик мэдээлэл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гадаадаас авч ажиллуулах зайлшгүй шаардлагатай нарийн мэргэшлийн мэргэжилтний талаарх судалгаа зэрэгт тулгуурлан, холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн дэргэдэх 35 гаруй мэргэжлийн зөвлөлүүд, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон бусад оролцогч талуудаас саналуудыг нэгтгэн боловсруулж, яамдуудаас санал авч 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 359 дүгээр тогтоолоор 11 эдийн засгийн ангиллын 130 нарийн мэргэшлийн жагсаалтыг батлуулсан.</p> <p>Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг баталснаар уг жагсаалтад заасан мэргэшлийн гадаад ажилтанг авч ажиллуулахад ажил олгогч Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.9-д заасан зөвшөөрлийг нэмэлт шаардлагагүй авах эрх зүйн орчин бүрдсэн.</p> <p>Мөн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу “Монгол Улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 360 дүгээр тогтоолыг 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр батлуулсан.</p> <p>Тус тогтоолоор 2024 онд эдийн засгийн 21 салбараар 27851 гадаад ажилтанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохоор батлагдсан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх” гэж заасны дагуу мөн Монгол Улсын эдийн засаг тэлж, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа өргөжихийн хирээр, нөгөө талд хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, ажиллах хүчний хомсдол бий болж байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монголд зочлох жил” болон бусад бодлого, зорилтын хүрээнд бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг</p>
--	--	--	--	--	--

					<p>эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих шаардлага үүссэн. Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоодоос ирүүлсэн санал хүсэлтүүдийг харгалзан Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор Монгол Улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг гадаадын иргэний эрх зүйн байдлын хууль тогтоомжид нийцүүлэн уул уурхай, олборлолт, төрийн удирдлага, батлан хамгаалах, мэдээлэл, холбоо, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаанаас бусад салбаруудад хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн.</p> <p>Тус тогтоолуудын хүрээнд Монгол Улсад 2024 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар нийт 104 орны 14156 гадаад иргэн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу /идэвхитэй/ хөдөлмөр эрхэлж байна.</p> <p>Түүнчлэн “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2023 оны 477 дугаар тогтоолоор Гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 37 аж ахуйн нэгж, байгууллагын 10118 гадаад ажилтныг 2024 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэр гарсан.</p> <p>Уг тогтоолын дагуу 2024 оны эхний хагас байдлаар 26 аж ахуйн нэгж, байгууллагын 3810 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн. Мөн ажлын байрны төлбөрийн 50 хувийн хөнгөлөлтийг 158 аж ахуйн нэгж, байгууллагын 4964 гадаад ажилтанд үзүүлээд байна.</p>	
28	2.7. Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.	2.7.1. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээн хөгжүүлж, угийн бичиг хөтлөх, цус ойртолтыг багасгах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2020 - 2050	-	<p>“Угийн бичиг”-ийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг зохион байгуулж, нийт өрх, гэр бүлийн 30 хувьд хүрч ажиллана.</p> <p>- “Угийн бичиг” хөтлөхийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, өрх бүрт хөтлүүлэн хэвшүүлэх “Сургагч багш” бэлтгэх сургалтыг “Ураг удам, уламжлалын Холбоо” ТББ-тай хамтран зохион байгуулж, 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг, төрийн бус байгууллагын төлөөлөл 30 хүн танхимаар, орон нутгийн харьяа байгууллагын мэргэжилтэн, Соёлын төв, ТББ-уудын төлөөлөл 60 хүн цахимаар хамруулж, нийт “Сургагч багш” -аар 90 хүнийг бэлтгэсэн. Монголчуудын угийн бичиг, ургийн овог, удам судар, ёс заншил, гэр бүлүүдийн ураг төрлийн холбоог таниулж, ураг төрөл ойртсон гэрлэлтээс сэргийлж улмаар эрүүл саруул удамтай байх, угийн бичгийг хөтлөхийн ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх мэдлэгийг олгосон.</p> <p>2024 оны эхний 5 сарын байдлаар 21 аймаг, нийслэлийн хэмжээнд угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж 8877 иргэнийг хамруулж, шинээр 365 иргэн угийн бичгээ хөтөлсөн.</p>	50
<b>Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА</b>						
29	3.1. Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж,	3.1.1. Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах	2020 - 2050	Уг хуулийн Малчин, үйлчлэлд 2021 хувиараа оны жилийн хөдөлмөр эрхлэгч нь нэг сард 42 000 төгрөг (420 000	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Хуульд малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50%-ийг улсын төсвөөс 5 жилийн хугацаанд хариуцан төлөхөөр тусгасан. Энэхүү заалтын хэрэгжилт 2024 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхлэх тул Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд	70

	амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.	тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.		даатгуулагч хамрагдаж, 76.3 тэрбум төгрөгийн шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд нөхөн төлсөн байна. Үүнээс нийт 15.8 мянган иргэн тэтгэврээ тогтоолгосон бөгөөд тэтгэврийн зардалд 67.5 тэрбум төгрөг одоогийн байдлаар зарцуулсан байна.	төг*10%), нэг жилд 504 000 төгрөг (42 000 төг*12 сар)- өөр тооцож нөхөн төлсөн байна.	хуулийн хэрэгжилтийг хангуулахаар 55.1 мянган малчны шимтгэлд 25.1 тэрбум төгрөгийг тусгуулсан болно.	
30		3.1.2. Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	2020 - 2050	Гадаадын зээл, тусламж 238.5 мян. \$	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулсан байна.	Монгол Улсын Засгийн газар Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шатлгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжснээр тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилүүлэх, хуримтлал үүсгэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зэрэг томоохон өөрчлөлтийг тусгаад байна. Түүнчлэн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, олон жил шимтгэл хүмүүсийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх шударга бодолттой болох, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч нас барвал түүний олон жил хамт амьдарсан эхнэр, нөхрийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлдэг байх, бусад салбарын хуулиар нийгмийн даатгалын харилцааг зохицуулж байгааг хязгаарлаж зөвхөн нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд шийдвэрлэдэг байх, тэтгэвэр тогтоох дараалсан жил 7 байгааг 5 жил болгох, тэтгэврийг жил бүр инфляцтай уялдуулж нэмэгдүүлдэг байх, итгэлцүүрийг жил бүр шинэчлэн тогтоох, нийгмийн даатгалын засаглалыг сайжруулах, нийгмийн даатгалын сангуудаас олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхийг хуулиар хориглох зэргийг тусгасан.	100

31		3.1.3. Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.	2020 - 2050		Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь иргэн бүрт суурь тэтгэвэр олгох, уг суурь тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн судалгаа, бусад орны суурь тэтгэвэр олгож буй туршлага зэргийн судлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд иргэн бүрд суурь тэтгэвэр олгохоор хуулийн төслийг боловсруулж намын бүлэг, төрийн болон төрийн бус байгууллагаар хэлэлцүүлэхэд нийгмийн халамжийн тэтгэвэр нь суурь тэтгэвэр тул хасах саналыг ирүүлснээр хуулийн төслөөс хассан болно. Харин тэтгэвэр авагч нас барсан бол Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэр бүлээ бүртгүүлсэн, 20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр, эсхүл нөхрийн тэтгэврийн хэмжээг нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн 20 хувиар нэмэгдүүлэхээр хуулийн зохицуулалтыг нэмж тусгаж батлуулсан.	100
32		3.1.4. Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.	2020 - 2050		Нийгмийн даатгалын тухай багц хуультай хамт 2022 оны намрын чуулганд өргөн барина.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улмаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан 10 аймаг, нийслэлд ахмадууд, залуучууд, сайн дураар даатгуулагчид, үйлдвэрчний эвлэлийн шат шатны байгууллага, ажил олгогчдын төлөөлөл, худалдаа аж үйлдвэрийн танхим, хуульчдын холбоо зэрэг газруудаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг зохион байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Улсын Их хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужингаар ахлуулсан. Ажлын хэсэгт дэмжлэг тусалцаа үзүүлэх дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Нийгмийн бодлогын байнгын хорооноос баталсан. Энэ дагуу Ажлын дэд хэсгийн гишүүд хуулийн төслийн санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийгмийн бодлогын байнгын хорооны дэд ажлын хэсэг 12 удаа хуралдсан. Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг хэлэлцсэн. Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад саналаа хүргүүлсэн болно.	70
33		3.1.5. Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна. Нутгийн захиргааны байгууллагатай	2020 - 2050	-	Нийгмийн даатгалын цахимжуулсан үйлчилгээний тоо нэмэгдэж ажил олгогч, даатгуулагч иргэдэд үзүүлэх	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас буюу листийг цахимаар олгох шийдвэрийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудын ашигладаг E-Health системд хөгжүүлэлт хийж цахим лист олгох нөхцлийг бүрдүүлсэн. Бүх шатлалын эмнэлэг болон өрх, сумын эмнэлгүүд, хувийн эмнэлгүүдээс нийт 1258 эмнэлэг эмнэлгийн хуудсыг цахимаар олгож байна. Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар тогтоох, цахим хяналт, шалгалтыг сайжруулах, сумын төвөөс	90

		хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ.			үйлчилгээ чирэгдэлгүй, хялбар, шуурхай, хүнд сурталгүй болсон байна.	аймгийн төв рүү тэтгэврийн хувийн хэргийг шилжүүлэхгүй, зөөвөрлөх шаардлагагүй, нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэхээр баруун 8 аймгийн тэтгэврийн хувийн хэргийг 2022 оноос цахимжуулж дууссан. 2024 оны хагас жилийн байдлаар, Дархан, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах ажлыг эхлүүлсэн. Нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээний 24 үйлчилгээг нь цахимжуулсан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Ай ти зон” компани 2019-2023 онд нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг хөгжүүлэн энэ оноос нэвтрүүлж эхэллээ. 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш нийгмийн даатгалын цахим мэдээллийн шинэ системийг нэвтрүүлэх ажил үе шаттайгаар явагдаж, 2024 оны 03 дугаар сарын 15-наас төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал И-Монголиа системтэй холбон ажиллаж байна. E-Mongolia цахим системд 16 үйлчилгээг холбосон e-Mongolia цахим системээс 2024 оны 05 дугаар сарын 30-ны байдлаар 2.5 сая удаа нийгмийн даатгалын цахим үйлчилгээг авсан байна.	
34		3.1.6. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно.	2020 - 2050	-	2022 онд Холбогдох хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага” -аар хөрөнгө оруулалтын удирдлагыг нарийвчлан зохицуулсан болно. Мөн хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлтэй байхаар эрх зүйн орчинг бүрдүүлээд байна. Уг хуулийн 29 дүгээр зүйл “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр өвлүүлэх харилцааг зохицуулахаар тусгасан. Тэтгэврийн нөөц санг даатгуулагчийн төлөх шимтгэлийн 2 хувь, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу улсын төсөвт шилжүүлсэн орлого, улсын төсвөөс олгох бусад орлогоос бүрдүүлэхээр хуульчилсан. Ингэснээр даатгуулагч нөөц санд байршуулсан мөнгөжсөн орлогоосоо боловсрол, эрүүл мэнд, орон сууцны ипотект тухайлсан хуулиар зохицуулсны дагуу хөрөнгө оруулах боломжтой болсон.	90
35		3.1.7. Тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын орлогын өгөөж болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлнэ.	2020 - 2050	-	2022 онд Холбогдох хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Уг хуулийн 29 дүгээр зүйл “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх харилцааг нарийвчлан зохицуулсан. Өөрөөр хэлбэл тэтгэврийн нөөц санг даатгуулагчийн шимтгэлийн орлого, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу улсын төсөвт шилжүүлсэн орлогоос 3Г-ын тогтоосон хэмжээгээр, улсын төсвөөс олгох бусад орлогоос тус тус бүрдүүлэхээр тусгаж, эрх зүйн орчинг бүрдүүлсэн.	100
36		3.1.8. Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш	2020 - 2050		1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Уг хуулийн 29 дүгээр зүйл “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, 29.3.1-д “энэ хуулийн 18.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0	100

		төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.			бодит хуримтлал болгох зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна.	хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого;" гэж тусгасан бөгөөд үүнд 1979 оноос хойш төрсөн даатгуулагч хамаарах бөгөөд ингэснээр тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлалд шилжүүлэх эрх зүйн орчин бүрдээд байна. 2024 онд 380 гаруй тэрбум төгрөгийн шимтэлийг бүрэн хуримтлал болгох юм.	
37		3.1.9. Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ.	2020 - 2050		Нийгмийн даатгалын тухай ерөнхий хуулийн төсөлд тусгасан байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Уг хуулийн 29 дүгээр зүйл "Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх"-ээр хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих эрх зүйн орчин бүрдээд байна. Тухайлбал, 2024 оноос эхлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.1-д "энэ хуулийн 18.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого;" гэж заасны дагуу шимтгэлийн орлогыг хуримтлал болгох арга хэмжээ үе шаттай хэрэгжүүлж байна.	100
38		3.1.10. Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ.	2020 - 2050		Хуулийн төсөл боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Нийгмийн халамжийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох яамдаас саналыг авч нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/2831 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны 8 дугаар сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн ХЭГ/1996 дугаар албан бичгээр буцаан ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан яам, агентлагын ажлын хэсэг 2023 оны 3-4 дүгээр сард Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин сайжруулах, холбогдох баримт бичгийн тоо мэдээллийг шинэчилж Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцоог дахин боловсруулж ажиллав. Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, тандан судалгааг яамны холбогдох газар, сайд, удирдлагын түвшинд танилцуулж байна. Хуулиудын төслийг 2023 оны УИХ-ын намрын чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Хуулийн шинэчлэлээр нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгох, давхардлыг арилгаж халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай зорилтот бүлэгт тэтгэвэр, тэтгэмжийг чиглүүлэх үндсэн зарчмыг баримтлахаас гадна нийгмийн халамжийн одоогийн хуулийн хүрээнд зорилтот бүлгийн иргэд, өрхүүдэд зөвхөн мөнгөн тусламж үзүүлдэг хэт нэг талыг барьсан бодлогоос татгалзаж, нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдийг чадавхжуулах, тэдний хэрэгцээнд нийцсэн шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан.	70

					<p>2023 оны 9 дүгээр Дэлхийн банкны ТСТББТ-ийн хүрээнд Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэл дээр дотоодын зөвлөхийг ажиллаж байна. Энэ хүрээнд дээрх хуулийн төслүүд дээр ажиллаж саналын хувилбарыг боловсруулсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд шинээр орсон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний судалгаа болон дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцооллыг боловсруулахад хамтран ажилласан. Хуулийг төслүүдийг 2023 оны 11 дүгээр сарын 15,16-ны өдөр ХХҮЕГ-аас зохион байгуулсан 21 аймаг, 9 дүүргийн халамжийн сан, олголт хариуцсан мэргэжилтнүүдэд, 23, 24-ний өдөр Багануур, Хэнтий аймгийн ХХҮ-ний газар, хэлтсийн мэргэжилтэн, сум, хорооны нийгмийн ажилтнуудад, 12-р сард нийслэлийн төсвийн 6 дүүрэг болон ШШГЕГ, СЭМҮТ, ОБЕГ, мэргэжлийн холбоод зэрэг бусад оролцогч талуудаар хэлэлцүүлж санал авч тусгалаа. Мөн түүнчлэн халамжийн тогтолцооны өнөөгийн байдал, шинэчлэх хэрэгцээ шаардлага болон шинэчлэлийн үзэл баримтлалын талаар бодлого боловсруулагчдад зориулсан гарын авлагыг боловсруулж хэвлэхэд бэлэн болгосон.</p> <p>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Сангийн сайдтай 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдөр хамтран батлав.</p>	
39	3.1.11. Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг блокчейн технологид суурилан боловсронгуй болгож, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.	2020 - 2050	Дэлхийн банкны 4500\$	<p>Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлсэн аргачлал батлагдсан байна.</p>	<p>Засгийн газраас төрийн байгууллагуудын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрд цугларсан их өгөгдлийг төрийн бодлого шийдвэрт ашиглах, төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчин бүрдэж эхэлсэнтэй холбоотойгоор өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Ингэхдээ төрд байгаа мэдээлэлд суурилан өрхийн орлогыг орлуулан тооцох боломжтой, өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлэхээр зорьсон.</p> <p>"Орлогыг орлуулан тооцох арга өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал", "Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал"-ыг тус тус боловсруулж Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/14, А/04 дүгээр хамтарсан тушаалаар баталсан.</p> <p>Энэхүү аргачлалыг шинэчлэн батлахдаа 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг үндсэн мэдээлэл болгож ашигласан бөгөөд үүн дээр нэмж төрийн мэдээллийн санд бэлэн байгаа, хууль, эрх зүйн орчны хүрээнд ашиглах боломжтой өрх, иргэний мэдээллийг регистрийн дугаараар холбон холимог мэдээллийн сан үүсгэсэн. Уг аргачлалд Орлогыг орлуулан тооцох арга зүйг хэвээр ашигласан хэдий ч ашигласан мэдээллийн эх үүсвэр нь холимог байгааг харгалзан ООТА-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох Хосолмол аргачлал гэж нэрлэсэн.</p> <p>Уг аргачлалын дагуу хүүхдийн мөнгийг 91 хувьд олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн түүнчлэн уг аргачлалын дагуу хүнсний эрхийн бичигт хамрагддаг 26.9 мянган өрхөөс судалгаа авах ажлыг 2023 оны 5 дугаар сард зохион байгуулж ажилласан. Судалгааны урьдчилсан дүнгээр нийт хамрагдах</p>	90

					<p>өрхийн 99.1% хамрагдсан бөгөөд 2023 онд багтаан эрүүл мэндийн даатгал, татвар зэрэг төрийн бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх ажил хийж дуусгах юм. Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлээр халамжийг хэрэгцээ, шаардлагатай хэсэгт чиглүүлэх, амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдалтай уялдуулах тул энэ аргачлалын дагуу бүрдсэн мэдээллийн сангийн ашиглалт нэмэгдэх бөгөөд цаашид төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох замаар Монгол Улсын бүх өрхийн амьжиргааг үнэлэх, өрхийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх шаардлагатай байгаа юм.</p>	
40		<p>3.1.12. Зорилтот бүлгийн өрхийг хөгжүүлэх, хамгаалах, тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх орон нутгийн онцлогт нийцсэн шинэ төрлийн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.</p>	2020 - 2050	АХБ-ны төсөл 1,7 тэрбум	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, бусад үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан.</p> <p>Энэхүү үйлчилгээг хэрэгжүүлэх загвар, аргачлалыг тодорхойлох зорилгоор дэлхийн улс орнуудын эмзэг бүлгийн өрхийг бие даан амьдрах, тогтвортой амьжиргаанд хүргэх ижил төстэй загваруудыг судалсан. Үүний нэг нь бусад оронд амжилттай хэрэгжиж байгаа “төгсөлтийн аргачлал” хөтөлбөрийн загвар бөгөөд энэ нь ядуу өрхүүдийн авч байгаа нийгмийн халамжийн тэтгэмжид суурилан ядуурлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, ядуурлын олон асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг олон хэмжээст аргачлал юм.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Төгсөлтийн аргачлал” туршилтын хөтөлбөрийг ЧД, БЗД, СХД - үүдэд 2022 оны 6 дугаар сараас эхлэн нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмж болон хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч буй зорилтот 1,520 санамсаргүй түүврийн аргаар сонгож суурь судалгаанд хамруулсан.</p> <p>АйАрЭм судалгааны байгууллагын оролцоотойгоор зах зээлийн судалгааг хийлгэж, сонгогдсон өрхүүдийн хөдөлмөр эрхлэх бизнесийн богино жагсаалтыг боловсруулж ажилласан.</p> <p>Дээрх жагсаалтын дагуу хөтөлбөрт сонгогдсон өрхүүдийн хөдөлмөр эрхлэхэд бэлэн байдлын (профайлинг) үнэлгээг өрхөд тохирох бизнесийг сонгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлгийн болон цогц сургалт, уулзалтуудыг зохион байгуулсны үр дүнд уг туршилтын хөтөлбөрт нийт 1,281 өрхийн бизнесээ сонгосон.</p> <p>Одоогоор өрхийн сонгосон бизнесийн чиглэлээр Техникийн анхан шатны ур чадвар олгох явагдаж байгаа болно.</p> <p>Цаашид эдгээр өрхийн бизнес сонгосон 1281 өрхөд өрхийн амьжиргааг дэмжих, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлж орлого олгох тоног төхөөрөмжийг олгох юм.</p> <p>Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгох, давхардлыг арилгаж халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай зорилтот бүлэгт тэтгэвэр, тэтгэмжийг чиглүүлэх үндсэн зарчмыг баримтлан Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийг боловсруулсан. Нийгмийн</p>	90



					халамжид хамрагдаж байгаа зорилтот өрх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлаас гаргах урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлнэ. Энэ нь өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, засалд хамруулах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, орлогын тогтвортой эх үүсвэр, хуримтлалтай болгох зэрэг цогц халамжийн зорилтот шинэ төрлийн үйлчилгээг мэргэжлийн Төрийн бус байгууллага, орон нутгийн оролцоотой хэрэгжүүлэхээр тусгана. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд суурилсан байдлаар төрөлжүүлэн хуулийн төсөлд тусгаж, орон нутгийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Үйлчилгээг зорилтот бүлгийн иргэний хэрэгцээ, нөхцөл байдлын үнэлгээнд түшиглэн үйлчилгээнд хамруулах төлөвлөгөөг гаргаж, үйлчилгээг тодорхой давтамжаар хүргэж болохоор тусгасан.	
41	3.1.13. Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.	2020 - 2050		Төлөвлөгөөг батлан 2022 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган загвар төвийн үйл ажиллагааны чадавхи бэхжүүлэх 3-аас доошгүй сургалт зохион байгуулах	Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр ХНХЯ, ЭМЯ хамтран 3 зорилтын хүрээнд 24 үйл ажиллагаа бүхий “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022 оны А/127, А/333 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулав.Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн удирдлага, холбогдох 30 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан цахим сургалтыг 14 хоног тутам зохион байгуулдаг. Сургалтаар төвийн үйл ажиллагаа явуулахад мэрэгжил арга зүйн зөвлөгөө өгөх, төвүүд харилцан туршлага солилцох, тулгамдсан асуудлыг хэлэлцүүлдэг.</li> <li>• “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн ажилтнуудыг хамруулсан сургалтыг 2024 оны эхний хагас жилийн байдлаар 3 удаа зохион байгуулав.</li> <li>• Кейс менежментийн практикийн үндэс” сургагч багшийн сургалтыг 04 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтаар “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн мэргэжилтнүүд, нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хэрэгцээний цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааг баримтжуулах ур чадваруудыг эзэмшсэн. Дээрх сургалтад хамрагдсан сургагч багш нар орон нутагтаа кейс менежментийн үйлчилгээг танилцуулах, үр дүнтэй хамтын ажиллагааг хангах зорилгоор 2024 оны 05 дугаар 28-30-ны өдрүүдэд сургалтыг тус тус зохион байгуулав.</li> </ul>	90
42	3.1.14. Эхний ээлжид эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална.	2020 - 2050	107,0 сая төгрөг	“Оролцоо” төсөлд хамрагдсан залуучуудын 30-с доошгүй хувь нь эмзэг бүлгийн өрхийн гишүүн байна.	Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулах замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөл, “Эрэлтэд нийцсэн ур чадвар” хөтөлбөр, “Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийг тус тус хэрэгжүүлж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2021 оноос эхлэн 18-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон хүнсний</li> </ul>	100

				<p>эрхийн бичигт хамрагдаж буй өрхийн хөдөлмөрийн насанд хүрсэн 34 хүртэлх насны залуучуудыг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадварт суралцуулж, ажлын байранд зуучлах зарчмаар хэрэгжүүлж байна. Төсөлд 2021 онд 2328, 2022 онд 1233 залуучуудыг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Төслийг 2023 онд зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд тогтоолын төсөл, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, батлуулахаар 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/1319 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна. Уг тогтоолын төсөл батлагдснаар “Оролцоо” төслийг өргөн хүрээнд зохион байгуулах, агуулгын хувьд зөөлөн ур чадвараас гадна бусад шаардлагатай ур чадварыг залуучуудад олгох боломжтой болно.</li> <li>Батлан хамгаалах яамтай хамтран “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдаж буй 1500 оюутан, залуучуудыг хамруулж, “Оролцоо” төслийн сургалтын үндсэн агуулга болох хувь хүний хөгжил, манлайлал, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар /soft skills/, хөдөлмөрт бэлтгэх чиглэлийн хичээлүүд болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын агуулгыг зааж 2.0 тэрбум төгрөгийг зарцуулсан. <b>/Энэ онд хэрэгжилт гараагүй/</b></li> <li>“Эрэлтэд нийцсэн ур чадвар”-ын хөтөлбөрийн төслийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрийг батлуулсан. Тус хөтөлбөр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн хүрээнд хэрэгжинэ. Тус хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, хувь хүний хэрэгцээнд тулгуурлан ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй, мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар болон мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах замаар ажилтай, орлоготой болгох, ажлын байраар хангах зорилготой.</li> </ul> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамжийн төслийг боловсруулан, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 сарын 27-ны өдрийн А/145 тушаалаар батлуулж хэрэгжүүлж ажиллах байгууллагуудад хүргүүлж чиглэл өгч ажилласан.</p> <p>Мөн эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Хөдөлмөр нийгмийн хамгааллын дэд сайдаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>“Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг ХНХСҮСИ-ийн захирлын 2024 оны А/41 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна.</p>
--	--	--	--	---

					<p>Сургалтын байгууллагуудын сонгон шалгаруулалтад нийт 32 сургалтын байгууллага хүсэлт ирүүлснээс нийт 16 сургалтын байгууллага тэнцсэн байна. Эдгээр МСБ-ын 40 багш, дадлагажуулагч нарт 2024 оны 05 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд “Арга зүйн чадавхжуулах сургалт”-ыг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Сургалтаар чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, чадамжийн нэгж бүр дээр материалын тооцоолол хийх, чадамжийн үнэлгээ төлөвлөх, онолын үнэлгээний тест боловсруулах арга зүй, ур чадварын үнэлгээний даалгавар боловсруулах арга зүйн талаар болон иргэний өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх /RPL/ үнэлгээний арга зүй талаар системтэй, дэс дараалалтай мэдээлэл өгч, оролцогчдоор дадлага ажил гүйцэтгүүлсэн.</p> <p>Мөн онолын сургалт, дадлага ажил гүйцэтгэснээр нийт оролцогчдын хувьд түвшин хоорондын ялгаа, үнэлгээ, үнэлгээг зохион байгуулахад үнэлүүлэгчийн сэтгэл зүйн орчин, материаллаг орчныг бэлтгэх талын мэдлэг, ойлголтыг бүрэн авч чадсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тус яам Япон Улсын ЖАЙКА байгууллагын дэмжлэгтэйгээр “Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийг 2023 оны 4 дүгээр сараас 2027 оны 3 дугаар сар хүртэл хэрэгжүүлнэ.</li> </ul> <p>Уг төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгждэг “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-т бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг тусган нэвтрүүлж, сайжруулах бодлогын зөвлөмж боловсруулах юм. Туршилтын төслийг Улаанбаатар хотын Баянзүрх, Сүхбаатар дүүрэг, Дундговь аймгийг хэрэгжүүлэх бөгөөд 1500 өрхийг хамруулах юм. 2024 оны эхний хагас жилийн байдлаар суурь судалгаа хийгдсэн болно.</p>	
43	3.1.18. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.	2020 - 2050	-	<p>“Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”- батлуулсан байна.</p> <p>- Төлөвлөгөөний хэрэгжилтийн</p>	<p>Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр ХНХ-ын сайд, ЭМ-ийн сайд хамтран 3 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны чиглэлтэй “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022 оны А/127, А/333 тоот хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна. энэ хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд төслийн худалдан авалтын төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжүүлэхээр сонгогдсон төвүүдэд 84 сая төгрөг бүхий тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж, төвүүдэд олгов. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> <li>- “Ачлалт хүүхдүүд” төрийн бус байгууллагад 32 сая төгрөгийн 21 төрлийн тоног төхөөрөмж,</li> <li>- Дархан-Уул аймгийн Ахмадын хөгжлийн төвд 28 сая төгрөгийн 15 төрлийн тоног төхөөрөмж,</li> <li>- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт 24 сая төгрөгийн 19 төрлийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөв.</li> </ul> </li> </ul>	90

					тайланг нэгтгэсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>• Түүнчлэн урт хугацааны тусламж үйлчилгээний загвар боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлсэн Япон, Тайланд, Вьетнам улсуудын загварыг харьцуулан судалсан.</li> <li>• ЭМЯ-тай хамтарсан төлөвлөгөөний дагуу “Кейс менежмент”-ийн зааврын төслийн ажлын хэсэгтэй хамтран боловсруулж туршилтын төсөл хэрэгжүүлэгч 3 байгууллагын төр, хувийн хэвшлийг оролцуулсан сургалтуудыг зохион байгуулсан байна.</li> <li>• “Кейс менежментийн практикийн үндэс” сургагч багшийн сургалтыг 04 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулсан.Энэхүү сургалтаар “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн мэргэжилтнүүд, нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хэрэгцээний цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааг баримтжуулах ур чадваруудыг эзэмшлээ.</li> <li>• Сургалтад хамрагдсан сургагч багш нар сонгогдсон 3 байгууллагад кейс менежментийн үйлчилгээг танилцуулах, үр дүнтэй хамтын ажиллагааг хангах зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулсан.</li> <li>• Түүнчлэн урт хугацааны тусламж үйлчилгээний загвар боловсруулах олон улсын загвар , туршлагаас тухайлбал Япон,Тайланд, Вьетнам улсуудын загварыг харьцуулан судалсан. ЭМЯ-тай хамтарсан төлөвлөгөөний дагуу “Кейс менежмент”-ийн зааврын төслийн ажлын хэсэгтэй хамтран боловсруулж туршилтын төсөл хэрэгжүүлэгч 3 байгууллагын төр хувийн хэвшлийг оролцуулсан сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж 20 хүнийг хамруулсан байна.</li> <li>• Мөн Азийн хөгжлийн банкны эрүүл мэндийн мэргэжилтэн Себил Вон төслийн олон улсын зөвлөхүүд 2024 оны 06 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд төслийн явц, үйл ажиллагаатай танилцаж, цаашид хэрэгжүүлэх төслийн талаар санал солилцохоор манай улсад ажиллсан. Энэ хүрээнд төслийн удирдах зөвлөлийн хурлыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар 2024-2026 онд хэрэгжих төслийн танилцуулга, хэрэгжиж байгаа төслийн явц ,үр дүнгийн талаар санал солилцов.</li> </ul> <p>Идэвхтэй насжилтыг дэмжих загвар төвүүдийн дотоод зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагаа болон үзүүлэх үйлчилгээ, тусламж дэмжлэгийн хөтөлбөрүүдийн удирдамж, заавар бүхий гарын авлагын төсөл боловсруулсан.</p>	
44	3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, дунд эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	3.3.1. Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэгчдийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулж	2020 - 2050	1.6 тэрбум ХЭДС	Ажлын хэсэг	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөрүүд болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан.</p>	90

		<p>зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно.</p>			<p>Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны зорилго нь ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнесийг эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бусад холбогдох дэмжлэг үзүүлэхэд оршино.</p> <p><u>Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд:</u> 2024 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 437 иргэн хамрагдаж, 1,608,838,000 төгрөгийг зарцуулсан байна. Арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 81 иргэн хамрагдаж, 793,150,000 төгрөгийг</li> <li>• Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 23 иргэн хамрагдаж, 203,750,000 төгрөгийг;</li> <li>• Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 69 иргэн хамрагдаж, 506,500,000 төгрөгийг;</li> <li>• Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 4 иргэн хамрагдаж, 26,620,000 төгрөгийг;</li> <li>• Түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 260 иргэн хамрагдаж, 78,818,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</li> </ul> <p>Түүнчлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7-д заасны дагуу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан.</p> <p>Үүний дагуу аж ахуй, бичил бизнес үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэний төсөлд 10.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгодог байсныг өөрчлөн үе шаттайгаар дэмжин, авсан санхүүгийн дэмжлэгээ эргэн төлсөн тохиолдолд бизнесээ өргөжүүлэх нь зориулж 10.0-20.0 хүртэл сая төгрөг олгох, мөн малгүй болон цөөн малтай малчинг малжуулах төсөлд 5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож байсныг зудын нөхцөл байдлын үнэлгээ, малын хорогдлыг харгалзан 3 түвшинд үнэлэн 30.0 хүртэл сая төгрөг болгон нэмэгдүүлж амьжиргааны эх үүсвэрээ алдсан малчдад дэмжлэг үзүүлэх, санхүүгийн дэмжлэгт хамрагдсанаас хойш 2 жилийн хугацаанд санхүүгийн дэмжлэгт дахин хамрагдахгүй байх зохицуулалттай байсныг өөрчлөн бизнесээ тасралтгүй өргөжүүлэхэд үе шаттайгаар дэмжих зохицуулалтыг тусгасан болно.</p>	
45	3.3.6. Салбарын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгоно.	2020 - 2050	1,500.0 Дэлхийн банк	453.0	<p>Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх зорилгоор Хиймэл оюун ухаанд суурилсан Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлж ашиглалтад оруулсан. “Ejob” платформ нь Онлайн портал, мобайл аппликэйшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрдэнэ.</p> <p>Системийн хүрээнд хэрэглэгч өөрийн анкет буюу CV-г байгууллагуудад илгээх, амьдарч буй байршлаас хамааран 1-10 км радиусын хүрээнд ажил хайх, байршлаас үл хамааран ажлын байртай болох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</p>	90

					<p>үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах боломжуудыг бүрдүүлсэн. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэн монголд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай системээр дамжуулан холбогдож, гэрээт ажил, үүрэг гүйцэтгэх, мөн эх орондоо эргэж ирээд ажиллах боломжийг бүрдүүлсэн. Тус платформоос ухаалаг тайлан гарч байхаар хөгжүүлэлтийн ажил хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/82 тоот тушаалаар баталсан маягтын дагуу хөдөлмөрийн зах зээлийн захиргааны статистикийн сарын тайлан мэдээ,</li> <li>- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тайлан,</li> <li>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны тайлан мэдээ,</li> <li>- Хөдөлмөрийн хувийн биржийн тайлан мэдээ болон бусад тайлан мэдээ.</li> </ul> <p>Түүнчлэн “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр “Ejob” платформын чанарын баталгааны 18 сарын хугацаанд техникийн туслалцаа үзүүлэх мэдээллийн технологийн ахлах зөвлөхийг 2023 оны 6 дугаар сараас 2024 оны 6 дугаар сарыг дуустал хугацаанд сонгон шалгаруулж, авч ажиллуулж байна. Мэдээллийн технологийн ахлах зөвлөх нь ажлын даалгаварт туссан ажил үйлчилгээ аливаа алдаа, дутагдал, доголдол илэрвэл нэн даруй залруулах болон засвар шинэчлэлийг хийхэд тухай бүр мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтран ажиллана.</p> <p>Мөн Чанарын баталгааны 18 сарын хугацаа “Ejob” платформыг гүйцэтгэгч байгууллагаас бүрэн хүлээж авах үйл ажиллагааны хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ажил эрчимжүүлж, яаралтай арга хэмжээ авч ажиллах үүрэг даалгавар хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/204 дүгээр тушаалын дагуу холбогдох ажлыг хийж, “Ejob” платформын үйл явцын талаарх тайлан мэдээг 10 хоног тутам авч нэгтгэн үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулж байна. 2024 оны 6 дугаар сарын байдлаар “Ejob” платформд нийт 37.3 мянган идэвхитэй ажлын байр, 34.2 мянган идэвхитэй ажил хайгч бүртгэлтэй байгаа бөгөөд тус системээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтний оролцоотойгоор жил хагасын хугацаанд 44.5 мянган хүн ажилд зуучлагдсан.</p> <p>Үүнээс дундын зуучгүйгээр 6,7 мянган иргэн ажил хайгчаар бүртгүүлж, 1173 иргэн нь ажлын байранд зуучлагдсан байна. Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо-8.3 мянга, тус платформд хандсан иргэдийн тоо-55.9 мянга болсон байна.</p>	
46	3.3.12. Хүн амын бүтээлч санаачилга, хандлага, ур чадвар, зан үйл болон үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд	2020 - 2050	17.5 тэрбум	5000 хүн	<p>Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем /ejob/ шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан 2023 онд Мэдээллийн технологийн төв, Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн нэгжтэй, Ай Ти Зон ХХК-тай хамтран Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэдээллээр хангах үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээ хийх үйлчилгээг</p>	90

		чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.		Төслийн зүгээс профайлингийн үйлчилгээг Төрийн болон Хувийн хөдөлмөр эрхлэлтийн албадад нутагшуулах ажлын хүрээнд 2022 онд нийт 125.000 Ам Долларыг зарцуулахаар төлөвлөн  Европын Холбооны санхүүжилтээр НҮБХХ-ийн “Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс санхүүжүүлж байна.	50000 хүн	үзүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын албан хаагчдыг мэргэжилт арга зүйн удирдлагаар хангаж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хяналт тавих талаар үе шаттай цахим болон танхимын сургалтыг 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 736 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан. Үйлчлүүлэгч төвтэй аргачлалыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан ажилгүй болон ажил хайгч, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнийг хувь хүний хэрэгцээнд үндэслэн профайлинг буюу хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх зорилт тавин улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Дээрх үйлчилгээг хэрэгжүүлэхээр 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Монгол Улсад ажилгүй байгаа нийт иргэдийн ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах, мэдээллийн сан үүсгэх зорилгоор нийт 50 мянган ажилгүй иргэнд хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээг хийх хүрээнд 2022 онд 14 мянган иргэнд, 2023 онд 19 мянган иргэнд, 2024 оны 6 дугаар сарын байдлаар 5 мянган иргэн, нийт 38 мянган иргэнд хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээг хийж хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх төлөвлөгөө гарган төлөвлөгөөг нь хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.	
47		3.3.13. “Залуу энтрепренершип” үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	2020 - 2050	780.0 сая	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр  1800 хүн	Залуучуудын хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх мэдлэг олгох ур чадвар эзэмшүүлэх зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэхүү санхүүгийн дэмжлэгт хамрагдах насыг 30 байсныг 25 нас болгосон тул тус дэмжлэгийг залуучууд авах боломж нээгдсэн. 2024 оны 06 дугаар сарын байдлаар нийт 437 иргэн хамрагдаж, 1,608,838,000 төгрөгийг зарцуулсан байна. Арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл: <ul style="list-style-type: none"> <li>Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 81 иргэн хамрагдаж, 793,150,000 төгрөгийг</li> </ul>	70

						<ul style="list-style-type: none"> <li>• Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 23 иргэн хамрагдаж, 203,750,000 төгрөгийг;</li> <li>• Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 4 иргэн хамрагдаж, 26,620,000 төгрөгийг;</li> </ul> <p>Түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 260 иргэн хамрагдаж, 78,818,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p>	
48	3.3.14. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ.	2020 - 2050	800.0 сая төгрөг	75 хүн	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам санаачлан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай болон холбогдох бусад хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран Шилдэг стартап болон залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох улсын уралдааныг зохион байгуулж байна. Уралдааны зорилго нь Улсын хэмжээнд шинэ технологи, инновац шингээсэн гарааны бизнес эрхэлж буй залуучуудад гарааны санхүүжилт олгох, мэргэжлийн менторууд, бизнес эрхлэгчдээс зөвлөгөө авч бизнесээ илүү боловсронгуй болгох боломжийг бүрдүүлж, дараагийн шатны санхүүжилтийг олгох, бизнес санааг нь улсын хэмжээнд сурталчлан таниулах зорилготой. Улсын аварга шалгаруулах уралдаан нь 2024 оны 5 дугаар сарын 14-29-ний өдрийн хооронд зохион байгууллаа. Улсын аваргад шалгарсан эхний 6 багт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-аас эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр нийт 99,000,000 төгрөгийн санхүүжилтийг олгоно. Үүнд:</p> <p>1-р байр 1 баг: 20,000,000 төгрөг  2-р байр 2 баг: 17,000,000 төгрөг /баг тус бүр/  3-р байр 3 баг: 15,000,000 төгрөг /баг тус бүр/</p> <p>Шилдэг стартап болон залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох улсын уралдаанд нийт 198 залуу, залуучуудын баг бүртгүүлж, үүнээс 1-р шатанд 40 баг шалгарлаа. Bootcamp 3 хоногийн хөтөлбөрт нийт 40 баг оролцож түүнээс 2-р шат буюу "Дэмо дэй" хөтөлбөрт оролцох 12 багийг шалгаруулан шилдэг 6 багийг тодрууллаа. Мөн шилдэг 12 багаас 7 багийг Камбож улсад 2024 оны 6 дугаар сарын 06-09-ний өдрийн хооронд зохион байгуулагдах CUE олон улсын тэмцээнд оролцох болсон.</p>	90	
49	3.3.15. Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.	2020 - 2050	Төсөл 2019-2021 оны 12 сард дууссан	21 аймаг, 9 дүүрэг, нийслэлийн загвар төв	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийн хүрээнд Шинэ технологи (финтек) ашиглан цахим хэлбэрээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг олгох үйл ажиллагааг банк, санхүүгийн байгууллагуудад дамжуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны А/76 дугаар тушаалаар финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг цахимаар дамжуулан олгох санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж сонгон шалгаруулах үйл</p>	70	



					<p>ажиллагааг зохион байгуулж Энт кредит инвестмент ББСБ шалгарч ХХҮЕГ-тай 2023 оны ХХҮЕГ/24 тоот гэрээ байгуулан үйлчилгээг Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэрээний хүрээнд 2023.06.22-ны өдөр 701.400.000 төгрөг 2023.09.28-ны өдөр 300.600.000 төгрөг нийт 1,002,000,000 эх үүсвэрийг Энт кредит инвестмент ББСБ-д шилжүүлсэн.</p> <p>2024 оны 6 дугаар сарын байдлаар 11679 иргэнд 6,457,200,000 төгрөгийн зээл олгосон байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотод 8981 иргэнд 4,935,100,000 төгрөг,</li> <li>- Дархан-Уул аймагт 2698 иргэнд 1,521,600,000 төгрөгийн зээл олгосноос 400,000 төгрөгийн 6672 иргэнд, 600,000 төгрөгийн 2385 иргэнд, 800,000 төгрөгийн 1384 иргэнд, 1,000,000 төгрөгийн 1238 иргэнд олгосон байна.</li> </ul> <p>Нийт идэвхтэй байгаа 2165 иргэний 1,338,400,000 төгрөгийн зээл байгаагаас Улаанбаатар хотод 1656 иргэний 1,026,400,000, Дархан-Уул аймагт 509 иргэний 312,000,000 төгрөгийн зээл олгосон байна.</p> <p>Цаашид Хур болон бусад систем ашиглан иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгч гэдэг мэдээллээ оруулан зээлээ шууд судлуулах боломжтой байхаар программ хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.</p>	
<b>Долоо. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ</b>						
50	<p>7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зогсоох бэхжүүлж, нийгмийн тайван бэхжүүлнэ.</p>	<p>7.3.7. Хүүхэд, сэмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, тасланурьдчилан сэргийлэх, чадавхыг нөлөөллийн арга хүн-хэмжээг нийгмийн амарбайгууллага, төр, орчны хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.</p>	2020-2050	99,4 сая вон	<p>Сургалт зохион байгуулах: /Цагдаагийн байцаагч-30 Хүүхэд хамгааллын ажилтан-30 Хилийн хяналтын офицер-30 Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд-30/ -Удирдамжийн практик хэрэглээг дэмжих; -Удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яамтай хамтран “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийг 5 жилийн хугацаатай амжилттай хэрэгжүүлсэн. Төсөл нь хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх замаар холбогдох бодлого, хөтөлбөрт нөлөөлөх, хэрэгжилтэд олон талт оролцоог нэмэгдүүлэх үндсэн зорилготой бөгөөд төслийн гүйцэтгэгч байгууллагаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хүйсийн тэгш эрх төв ТББ ажиллалаа. Төслийн хаалтын үйл ажиллагааг Бүгд Найрамдах Солонгос Улсын Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-тай хамтран 2023 оны 11 дүгээр сарын 8-9-ний өдөр зохион зохион байгууллаа. Донор байгууллага буюу БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яамнаас энэ төслийг 100 хувийн амжилттай хэрэгжсэн гэж үзсэн болно. Цаашид эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад улс орнуудтай хамтран ажиллах шаардлагатай байна.</p>	100

				80,0 сая	Эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.		
51	7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлнэ.	7.3.11. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.	2020 - 2050	138,7 сая төг	Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв /ТХБ, НЦҮТ/-ийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна.	Улсын хэмжээнд 36 ТХБ, НЦҮТ-өөр 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 1045 иргэнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлснээс 375 насанд хүрэгч, 670 хүүхэд, 17 насанд хүрэгч урт хугацаагаар байрлаж аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээнд хамрагдсан. Үүнээс 670 хүүхдийн 391 эмэгтэй /58.3%/, 279 эрэгтэй 41.7%/, 375 насанд хүрэгчийн 314 эмэгтэй /83.7%/, 61 эрэгтэй /16.3%/ байна.	100
<b>Нийт арга хэмжээний хэрэгжилт</b>							<b>86,07</b>

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН  
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЯВЦЫН ТАЙЛАН МЭДЭЭ**

№	Шалгуур үзүүлэлт[2]	Хэмжих нэгж[3]	Суурь түвшин[4]		Зорилтот түвшин[5]		Тайлант хугацааны хүрсэн түвшин[6]	Шалгуур үзүүлэлтийн тайлбар[7]	Мэдээлэл цуглуулах арга зүй, эх үүсвэр[8]	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)[9]	Хариуцах байгууллага
			Он	Түвшин	Он	Түвшин					
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
26	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	хувь	2020	84.4	2025	90	67.0%	2024 оны 07 дугаар сарын байдлаар 976.0 мянган даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдсан байна. Ажиллах хүчний тоог 2024 оны 2 дугаар улирлаар авав. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн даатгалын мэдээллийн шинэ систем нэвтэрсэнтэй холбогдуулан аргачлал өөрчлөгдсөнтэй холбогдож даатгуулагчийн тоо буурсан.	Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ-ны 1212.mn сайт	Зорилтод түвшний үзүүлэлт жилд нэг удаа гардаг.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага